



**ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 18

Дархан сум

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2026 оны
Бизнес төлөвлөгөөг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1, Компанийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.5.9, Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 01/3914 тоот албан бичгээр ирүүлсэн удирдамж, Төлөөлөн удирдах зөвлөлийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 05 тоот тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөдөө аж ахуйн бирж” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2026 оны Бизнес төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан Бизнес төлөвлөгөөний хүрээнд үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг бүтцийн нэгж тус бүрээр гаргаж, биелэлтийн явц, үр дүнг хагас, бүтэн жилээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тайлагнан, мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо /Б.Ариунболд/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.БОЛОРЧУЛУУН



“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ХХК-ИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ /2026 ОН/

Дархан Юнайтед Арена, Олимпын гудамж 45059, 14 дүгээр баг
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байр, 1 давхар
Монгол Улс, Дархан-Уул аймаг, Дархан сум

2025 он

АГУУЛГА

1	БИЗНЕСИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1	КОМПАНИЙН ТУХАЙ	3
1.1.1	Арилжаа	4
1.1.2	Клиринг, төлбөр тооцоо	8
1.1.3	Гишүүнчлэл	9
1.1.4	Итгэмжлэгдсэн этгээд	11
1.1.5	Санхүүгийн тайлангийн хураангуй	13
2	ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ	15
2.1	САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ	15
2.1.1	Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт	16
2.1.2	Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний импорт	19
2.1.3	Малын тоо, сүргийн бүтэц	21
3	БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ	24
3.1	КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ	24
3.1.1	Биржийн бүтэц, зохион байгуулалт	24
3.2	ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО	25
3.3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	26
3.3.1	Компанийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх	27
4	САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	33
4.1	ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖ	33
4.1.1	Зорилтот зах зээл, таамаглал	35
4.2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН БҮТЭЦ, ТААМАГЛАЛ	37
4.2.1	Арилжааны шимтгэл, орлогын төлөвлөлт	37
4.3	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	38
4.3.1	2026 оны үйл ажиллагааны төсвийн төсөл	39
5	ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ	41
5.1	ЭРСДЭЛИЙН ТӨРЛҮҮД	41
5.2	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	41
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ КАЛЕДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ	43

1.1 КОМПАНИЙН ТУХАЙ

“Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК нь Монгол Улсын Их Хурлын 2011 онд баталсан “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 30 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2013 оны 40 дүгээр тогтоолоор 2013 оны 03 дугаар сард байгуулагдсан бөгөөд “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн дагуу хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэгч малчин, тариаланч, хоршоо, үндэсний үйлдвэрлэгчдийн хооронд хийгдэх бараа, түүхий эдийн арилжаа болон бараа, түүхий эдийг экспортод гаргах арилжааг тогтсон журмын дагуу зохион байгуулах, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бий болгоход чиглэн ажилладаг байгууллага юм. Бирж нь одоогийн байдлаар 100 хувь төрийн өмчит компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

Бирж нь арилжааны зах зээлд оролцогчдыг түүхий эд бэлтгэлийн зохицуулалттай зах зээлд шилжүүлэх, олон улсын жишигт нийцсэн арилжааны платформыг нэвтрүүлснээр Монгол Улсын аймаг, сум бүрээс цахимаар арилжаанд оролцох боломжоор хангаж, хөдөө аж ахуйн салбарын түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид өөрийн хөдөлмөр, баялгийг зах зээлд зүй зохистой үнэлүүлэх, улмаар бизнесийн орчинд төлөвлөх боломжийг бүрдүүлж өгөхөд чиглэн ажилладаг.

Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар хуульчилсны дагуу Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны А/35, А/135 дугаар тушаалаар биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтад ноос, ноолуур, амьд мал, хүнсний буудай, тосны ургамал /рапс/-ыг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-409 дүгээр тушаалаар мах, арьс, шир, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/668 дугаар тушаалаар биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтад малын тэжээл болон үрийн улаанбуудайг нэмж жагсаалтад оруулан баталсан ба биржээр нийт 8 нэр төрлийн бараа, түүхий эдэд суурилсан спот гэрээний арилжааг танхим болон цахимаар зохион байгуулж байна. Хөдөө аж ахуйн биржийг 2022-2026 онд хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО



Монголын хөдөө аж ахуйн салбарын бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжих оновчтой тогтолцоог бий болгох замаар малчид, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, экспортын орлогыг өсгөх нөхцөлийг бүрдүүлнэ.

АЛСЫН ХАРАА

Компанийн засаглалыг сайжруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, арилжааны зах зээлд оролцогчдын тоог нэмэгдүүлэх, ложистикийн төвийг бий болгох, зах зээлийн дэд бүтцийг сайжруулах, зах зээлийн хөрвөх чадварыг дээшлүүлэх.



ҮНЭТ ЗҮЙЛС

Нэр хүнд, Хариуцлага, Үнэнч шудрага зарчим, Мэргэшсэн боловсон хүчин, Ёс зүй, Багаар ажиллах чавдар, Дэвшилтэд технологи нэвтрүүлэн олон улсын стандарт загварт нийцсэн “Хөдөө аж ахуйн бирж” Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болох.

2026 ОНЫ ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ

- *Эрхзүйн орчны шинэчлэл*
- *Худалдааг хөнгөвчлөх*
- *Үйл ажиллагааг өргөжүүлэх*

1.1.1 Арилжаа

Биржийн арилжаа нь бүхэлдээ цахим горимд явагдах бөгөөд танхимын болон онлайн гэсэн 2 хэлбэртэй. Танхимын арилжаа нь Санхүүгийн зохицуулах хорооноос Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй брокерын компани бүрийн тоогоор суудалтай бол цахим арилжааны оролцогчдын тоо хязгааргүй байх боломжийг бүрдүүлээд байна.

Биржийн арилжааг гэрээний онцлогоос шалтгаалан олон улсын жишгээр дуудлага худалдааны (call auction) болон үргэлжилсэн (continuous) арилжааны хэлбэрээр явуулна.

Дуудлага худалдааны арга нь тодорхой хугацаанд (5 мин) арилжаанд оролцогчдын захиалгыг бүртгэж, хамгийн их хэмжээ бүхий гэрээнүүд арилжаалагдах үнийг сонгох ба тухайн үнийг хүлээн зөвшөөрсөн санал бүхий захиалгууд үнэ, хугацаа гэсэн эрэмбээр биелнэ.

Үргэлжилсэн арилжааны хувьд захиалгуудын саналаар (ODM) болон тодорхой үнийн саналын загвар (QDM)-аар явуулах боломжтой. Захиалгуудын саналаарх загвар (ODM)-ын хувьд биелээгүй байгаа бүх нөхцөлт захиалгууд арилжаанд оролцогчдод нээлттэй харагдана. Харин тодорхой үнийн саналын загвар (QDM)-ын хувьд зөвхөн зах зээл үүсгэгчдийн оруулсан авах, зарах үнэ нийтэд харагдах бөгөөд бусад энгийн оролцогчдын нөхцөлт захиалгууд энгийн оролцогчдод харагдахгүй байна. Олон улсын жишгээр үүсмэл үнэт цаасны арилжааг үргэлжилсэн арилжаагаар явуулдаг.

Одоогоор биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтад ноолуур, ноос, мах, арьс шир, тосны ургамал, хүнсний буудай, малын тэжээл, үрийн буудай зэрэг 8 нэр төрлийн бараа, түүхий эд орсон ба тус бүрийн барааны тодорхойлолт, гэрээний стандартыг боловсруулан баталсан.

Барааны тодорхойлолт

Бирж нь зах зээлийн судалгаа, шинжилгээндээ тулгуурлан “Барааны тодорхойлолт”-ыг боловсруулан арилжих бараа, түүхий эдийн чанарт түүнийг мөрдлөг болгон ажиллаж байна. Барааны тодорхойлолтыг боловсруулахдаа арилжаанд оролцогч талууд мөрдөхөд хялбар байх, энгийн, ойлгомжтой байхад анхаарч, холбогдох үндэсний стандартад нийцүүлэн боловсруулдаг.

“Барааны тодорхойлолт”-д дараах үзүүлэлтийг тусгасан байдаг. Үүнд:

1. Бараа, түүхий эдийн нэр (ямааны ноолуур, хонины ноос, хүнсний буудай гэх мэт);
2. Биржийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх барааны код, кодлох аргачлал (барааны код нь 6 оронтой тоо байх ба нэр, өнгө, чанар, боловсруулалтын түвшин зэргийг илтгэнэ);
3. Биржийн барааны техникийн шаардлага (Биржээр арилжих бараа, түүхий эдэд зөвшөөрөгдөх доод үзүүлэлтийг тодорхойлно);
4. Хаяглалт, хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл (бараа, түүхий эдийн онцлогоос шалтгаалан ялгаатай байна);
5. Шаардлагатай бусад үзүүлэлт.

Биржийн арилжааны зах зээлд форвард, фьючерс гэрээний арилжааг нэвтрүүлэхтэй холбогдуулан арилжааны системд ашиглагдаж буй барааны тодорхойлолтуудад шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулж, холбогдох бичиг баримтуудад шинэчлэлт өөрчлөлт шат дараатай хийгдэнэ.

Биржээр арилжих бараа, түүхий эдийн баталгаажуулалт

“Монголын ноос, ноолуурын холбоо” ТББ-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоолоор батлагдсан “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг мөрдөн ажиллахад хамтран ажиллах, MNS ISO/IEC 17065:2013 стандарт баталгаажуулалтыг тус холбоогоор хийлгэн чанар стандарт хангасан баталгаатай түүхий эдийг Хөдөө аж ахуйн биржээр арилжиж байна.

Биржээр арилжих бараа, түүхий эдийн гэрээний стандарт

ГЭРЭЭНИЙ ТӨРӨЛ	СПОТ	ФОРВАРД
Суурилах бараа, түүхий эд	Гэрээгээр арилжих барааны нэр. Жишээ нь, “Ямааны ноолуур”	
Гэрээний код	001100-001324	“1”-“барааны код”-“дуусах огноо”
Богцын хэмжээ	10кг. Арилжих нэгж гэж ойлгоно. Өөрөөр хэлбэл, арилжаанд 8кг зарна эсвэл авна гэсэн ойлголт байхгүй.	10кг
Гэрээ хаагдах мэдэгдэл	Ажлын өдөр бүр	T+...
Хамгийн бага үнийн хэлбэлзэл	1000 төг. Арилжаанд үнэ өөрчлөгдөж болох нэгж	500 төг
Гэрээ хаагдах сар	1-12	Тухайн гэрээг хэд хэддүгээр сард хаагдахыг заана

Хүлээлцэх цэг	Итгэмжлэгдсэн агуулах	УБ + 21 аймаг
Арилжааны хуваарь	10:00-11:00	Тухайн гэрээ арилжигдах цагийн хуваарь
Гэрээ хаагдах горим	Арилжааны журам	Арилжааны журам
Сүүлийн арилжааны өдөр	Тухайн арилжааны өдөр	Гэрээг арилжих сүүлийн өдөр
Хүргэлтийн нөхцөл	T+7 (хүртэл)	-
Хүргэлтийн цэг	Итгэмжлэгдсэн агуулах	УБ + 21 аймаг Тухай барааг хүргэх (хүлээлцэх) цэг
Үнэ тогтох аргачлал	Дуудлага худалдааны арга	Дуудлага худалдааны арга, Үргэлжилсэн арга
Төлбөр тооцооны нөхцөл	T+1(бараа хүлээлцсэн өдрөөс)	T+5 Гэрээ хаагдсанаас хойш ... хүртэл хоногийн хугацаанд төлбөр тооцоог хийнэ.
Үнийн өөрчлөлтийн хязгаар	RP±10 %	RP±15 % Тухайн гэрээний үнэ өмнөх хаалтын эсвэл жишиг үнээс тодорхой хувиас дээш эсвэл доош үнэ тогтохгүй байхаар системд хязгаарлалт хийдэг ба тухай гэрээнд хэдэн хувиар тогтоохыг шийддэг
Хүргэлтийн горим	Тухайн бараа бүтээгдэхүүнийг хүргэх горим	Хүлээлцэх акт ...
Дэнчин	10%	Тухайн гэрээ бүрт дэнчингийн хэмжээг клирингийн албанаас тогтоон зарладаг
Хэмжээний /жин, тоо ширхэг гм/ нэмэгдэл хорогдол	± 5% Бараа, түүхий эдийн жин, ширхэг, тоо хэмжээнд тодорхой бага хэмжээний илүү болон дутсан хэмжээг хүлээн зөвшөөрөх бөгөөд тухайн хэмжээг тусгана.	± 10 %

Арилжааны мэдээ

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар 155 удаагийн арилжаа зохион байгуулж 644 удаагийн хэлцэлээр 3,068.32 тонн самнасан ноолуур, 5,849 тонн тосны ургамал, 987.5 тонн тэмээний ноос, 3,766.7 тонн хонины ноос, 1,797.9 тонн ямааны завод ноос зэрэг нийт 978.73 тэрбум төгрөгийн түүхий эдийн арилжаа, 1,940 ширхэг арьс шир, 60 тонн мах, 2139 толгой амьд мал, 51,034.1 тонн хүнсний буудай, 4,411.3 тонн үрийн буудай зэрэг нийт 59.8 тэрбум төгрөгийн дуудлага худалдааны арилжааг тус тус зохион байгуулсан.

Биржээр арилжсан бараа, түүхий эдийн хэмжээ, 2022-2025

	Хэмжих нэгж	2022	2023	2024	2025.12.15
Ямааны ноолуур	тн	7,788.9	6,300.0	5,840.6	3,126
Хонины ноос	тн	15,526.6	10,554.4	6,392.0	3,848.4

Тэмээний ноос	тн	1,692.4	986.8	1,020.6	987.5
Ямааны завод ноос	тн	1,787.8	2,379.1	3,400.7	1,798
Хонины завод ноос	тн	17.9	67.8	26.5	-
Тосны ургамал	тн	4,990.0	22,321.0	4,422.0	5,849.0
Хүнсний улаанбуудай	тн	-	100.0	778.0	95,209.12
Үрийн буудай	тн	-	-	1,066.0	12,011.3
Арьс шир	ш		4,400	-	4,825
Мах	тн	-	-	1,892.3	96
Мал /бог/	толгой	20	2,041	34,744	2,063
Мал /бод/	толгой	-	-	-	79
Малын тэжээл	тн	-	-	-	14

Арилжааны үнийн дүн, 2022-2025 /тэрбум төгрөг/

	Хэмжих нэгж	2022	2023	2024	2025.12.15
Ямааны ноолуур	тн	984.9	838.2	889.7	924.3
Хонины ноос	тн	25.6	16.2	13.8	8.7
Тэмээний ноос	тн	14.1	7.9	12.6	14.6
Ямааны завод ноос	тн	38.2	47.8	71.3	38.2
Хонины завод ноос	тн	0.21	0.1	0.3	-
Тосны ургамал	тн	7.5	30.7	7.6	9.9
Хүнсний улаанбуудай	тн	-	-	0.5	94.7
Үрийн буудай	тн	-	-	1.7	19.0
Арьс шир	ш		0.04	-	0.1
Мал, мах	тн	-	0.25	20.3	1.5
Малын тэжээл	тн	-	-	-	0.025

2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад арилжаатай өдрийн тоо буурч, арилжааны нийт үнийн дүн 1.5 хувиар буурсан байна. /Энэ нь биржийн арилжааны 90 орчим хувийг дангаар бүрдүүлдэг “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт” өөрчлөгдсөнтэй холбоотой/ Энэ оны хамгийн өндөр дүнтэй арилжаа 10 дугаар сарын 24-нд 27.7 тэрбум төгрөг байсан бол, 11 дүгээр сарын 28-ний өдөр хамгийн бага буюу 23 сая төгрөгийн дүнтэй арилжаа хийсэн байна. 2013-2025 оны байдлаар бирж нь нийтдээ 9.2 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа зохион байгуулсан байна.



1.1.2 Клиринг, төлбөр тооцоо

Хөдөө аж ахуйн бирж нь бараа, түүхий эдийн зах зээлийн өнөөгийн нөхцөл боломж, онцлогоос шалтгаалан худалдагч, худалдан авагч талуудын бараа, түүхий эд худалдах, худалдан авах гэрээг үндэслэн төлбөр тооцоо хийж гүйцэтгэх буюу 2 талт (bilateral) клирингийн зарчмаар клиринг, төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлдэг.

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулиар хүлээсэн нэг чухал үүрэг нь зах зээлд оролцогчдын эрсдэлийг бууруулах, төлбөр тооцоог эрсдэлгүй шуурхай гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлэх явдал юм.

Олон улсад клирингийн үйл ажиллагааг зах зээлийн онцлогоос хамааран хоёр талт (bilateral), төвлөрсөн (central) гэсэн 2 загвараар зохион байгуулж байна.

Хоёр талт (bilateral) клирингийн загварын хувьд хэлцэл бүрийн 2 тал тухайн хэлцэлд харгалзах төлбөр тооцооны эрх, үүргээ шууд эдэлнэ. Бирж үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг зохион байгуулахтай холбоотой төвлөрсөн (central) загварыг нэмж нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна. Клирингийн төвлөрсөн загварын хувьд хэлцэл бүр дээр оролцогчийн нөгөө тал нь Клирингийн төв байдаг. Энэ загвар нь оролцогчийн хувьд хэлцлийн нөгөө талын шийдвэрээс шалтгаалсан аливаа эрсдэлийг бууруулах боломжийг олгоно.

Клирингийн үйл ажиллагаанд дээрх 2 загварыг хослуулан ашигласнаар дараах зорилгыг хангана. Үүнд:

1. Хэлцэл баталгаажуулах;
2. Хэлцэл цуцлагдахаас урьдчилан сэргийлэх;
3. Хэлцэл хуваах, нэгтгэх, шилжүүлэх зэрэг хэлцлийн төлбөрийн үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;
4. Арилжаалж буй бараа, түүхий эд болон мөнгөн төлбөр тооцооны гүйлгээг эмхэтгэх;
5. Зах зээлийн гэнэтийн хэт өөрчлөлтөөс үүдсэн аливаа эрсдэлээс хамгаалах.

Дэнчин

Арилжаанд захиалга оруулж буй оролцогч биржээс тогтоосон хэмжээгээр дэнчин байршуулах замаар хэлцэл баталгаажуулах, хэлцэл цуцлагдахаас урьдчилан сэргийлэх зорилгыг хангадаг. Хөдөө аж ахуйн биржийн хувьд спот зах зээлд оролцогчийн өгөх боломжтой захиалгын дээд хэмжээ нь анхдагч дэнчинг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар журамласан. Харин гишүүн брокерын компанийн хувьд анхдагч дэнчингээс гадна баталгаат дэнчинг байршуулж байна.

Үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээл дээр анхдагч, баталгаат дэнчингээс гадна төлбөр тооцоо, хүргэлтийн дэнчинг нэмж тооцохоор төлөвлөж байна. Олон улсад дэнчинг тооцоолох хэд хэдэн түгээмэл арга байдаг ба бирж VaR (тухайн бүтээгдэхүүний үнийн түүхэн мэдээлэл дээр тулгуурлан дэнчин тогтоох аргачлал) загварыг ашиглаж байна.

Дэнчингийн хэмжээ

Дэнчингийн төрөл	Дэнчингийн хэмжээ	Байршуулах этгээд
Анхдагч	Нийт үнийн дүнгийн 10%	Арилжааны зах зээлд оролцогч
Баталгаат	20,000,000 төгрөг	Гишүүн брокер
Хүргэлтийн	Нийт үнийн дүнгийн 10%	Арилжааны зах зээлд оролцогч
Төлбөр тооцооны	Нийт үнийн дүнгийн 10%	Арилжааны зах зээлд оролцогч

Төлбөр тооцоо

Хөдөө аж ахуйн бирж нь Монгол Улсад хамгийн олон салбар, тооцооны төвтэй ХААН банк болон Худалдаа хөгжлийн банкаар дамжуулан арилжаанд оролцогчдын дэнчингийн гүйлгээ, худалдах, худалдан авах гэрээний төлбөр болон бусад өдөр тутмын төлбөр тооцоог хийдэг. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг эхлүүлснээр төлбөр тооцоог Төв банк болон арилжааны бусад банкуудаар дамжуулан зохион байгуулна.

Спот зах зээлийн төлбөр тооцоо нь t+1 зарчим буюу тухайн бараа, түүхий эдийн дараагийн үнэ тогтох хүртэл хугацаанд хийгдэж байна.

Хөдөө аж ахуйн биржийн төлбөр тооцоо гүйцэтгэх үндсэн валют нь төгрөг бөгөөд цаашид гадаад валют руу хөрвөх боломжтой гэрээг нэвтрүүлнэ.

Биржийн төлбөр тооцооны дүн, /сая төгрөг/

	2020	2021	2022	2023	2024	2025.12.15
Дебит	488,738.43	794,561.72	1,110,401.27	968,432.25	996,870.64	995,948.76
Кредит	488,738.43	794,561.72	1,110,401.27	968,432.25	996,870.64	995,948.76

1.1.3 Гишүүнчлэл

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хууль болон “Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”-д арилжааны зуучлагч /Брокер/-ийн арилжаанд оролцох үндсэн шалгуур нь зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай

зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан байхаар заасан бөгөөд энэхүү зохицуулалтын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч биржийн байнгын гишүүнээр арилжаанд оролцож байна.

Түүнчлэн “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуульд заасны дагуу “Хоршоо” нь тусгай зөвшөөрөл авах шаардлагагүйгээр байнгын бус гишүүнээр арилжаанд оролцох боломжтой.

Цаашид Монгол Улсын Засгийн газраас өрнүүлж буй “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг хэрэгжүүлэх таван (тав) их наядын “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд байгуулагдсан хоршоодыг биржийн байнгын бус гишүүнээр элсүүлж, чадавхжуулан биржийн арилжаанд татан оролцуулна.

Биржийн гишүүний тоо, 2020-2025

	2020	2021	2022	2023	2024	2025
Байнгын гишүүний тоо	7	6	5	7	7	7
Байнгын бус гишүүний тоо	-	2	71	86	94	30
Нийт гишүүний тоо	8	8	76	93	101	37

Биржийн гишүүнчлэлийн төрлийн хувьд байнгын болон байнгын бус гишүүнчлэлтэй хэвээр байх ба байнгын гишүүд гишүүнчлэл, арилжааны эрхийн хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулж, арилжаанд оролцоно.


Биржийн байнгын гишүүн – Клирингийн эрхтэй

Өөрийн эсвэл харилцагчиддаа клирингийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй биржийн гишүүн байна. Клирингийн эрхтэй гишүүд нь харилцагчдын арилжааны дэнчин, төлбөр тооцоотой холбоотой аливаа харилцаанд клирингийн үйлчилгээ үзүүлснээр төлбөр тооцоог илүү хялбар найдвартай болгодог.

Биржийн байнгын гишүүн – Зах зээл үүсгэх эрхтэй (market maker)

Зах зээл үүсгэх эрхтэй биржийн гишүүн нь өөрийн агуулахад бэлэн бараа, түүхий эдтэй хуулийн этгээд байх бөгөөд тодорхой бараа, түүхий эдийн фьючерс гэрээг худалдах болон худалдан авах үнийн саналыг тогтмол оруулах үүрэгтэй байна. Зах зээл үүсгэгч нь тухайн гэрээг худалдах, худалдах авах үнийн саналыг тогтмол оруулж байдаг учир зах зээлийг байнгын хөдөлгөөнтэй, хөрвөх чадвартай болгож байдаг.

Биржийн арилжаанд оролцогчид



Харилцагч – Хеджер (Hedger)

Бараа, түүхий эдийн үнийн өөрчлөлтөөс үүдэлтэй бизнесийн эрсдэлээ удирдахаар арилжаанд оролцож байгаа оролцогчдыг хеджер гэж нэрлэдэг. Бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгч, түүнийг худалдан авагч үйлдвэр, тухайн бараа, түүхий эдийн зах зээлд бизнес эрхлэгч гээд төрөл бүрийн оролцогчид биржийн арилжаанд оролцож, үнийн эрсдэлээ удирддаг.

Харилцагч – Спекулятор (Speculator)

Өөрт байгаа мэдээлэл, судалгаа, таамаглал зэрэгтээ үндэслэн биржийн арилжаанд ашиг олох зорилгоор оролцогчдыг энэ төрөлд авч үзнэ. Спекуляторууд ямар нэг гэрээг хямдхан худалдан авч үнэтэй зарах гэх мэтээр үнийн өсөлт бууралтын дүнд ашиг олох зорилготойгоор арилжаанд оролцдог.

Харилцагч – Арбитраж хийгч (Arbitrageur)

Олон зэрэгцээ зах зээлд зэрэг тоглож нэгээс авч нөгөөд зарах зэргээр ашиг олохоор арилжаанд оролцож буй оролцогчдыг хэлнэ. Намар буудай хямд худалдаж аваад ирэх оны 1 сард хүргэх үнэтэй форвард гэрээ зарж худалдан авсан буудайгаа хадгалаад 1 сард нийлүүлж ашиг олох нь арбитражийн жишээ юм.

1.1.4 Итгэмжлэгдсэн этгээд

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн хоёрдугаар бүлгийн тавдугаар зүйлийн 5.1.11 дэх заалтад агуулах, тээвэр, лаборатори зэрэг биржийн арилжаанд шаардлагатай оролцогчдын шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, тэдгээрт биржийн арилжаанд оролцох итгэмжлэл олгох тухай зохицуулсан. Эдгээр нь биржээр арилжигдах бараа, түүхий эдийн хадгалалт, хүргэлт, чанар стандартыг хариуцдаг чухал оролцогчид юм.

Гүйцэтгэх захирлын баталсан “Итгэмжлэгдсэн агуулахад тавигдах шалгуур үзүүлэлт”-ийг хангасан агуулахуудад биржийн итгэмжлэл олгодог бөгөөд итгэмжлэл хүсэгчтэй 3 жилийн хугацаатай Итгэмжлэлийн гэрээ байгуулан ажилладаг.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж, ахуйн байнгын хорооны 2025 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 19 дүгээр хуралдааны тэмдэглэлд тусгасан зах зээл дээрх ноолуурын худалдан авалтыг дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор жилийн 12 хувийн хүүтэй 500.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний энгийн вексель гаргах арга хэмжээг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Дээрх арга хэмжээний хүрээнд ноолуурын бэлтгэлийг хангуулах, үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр түүхий эд худалдан авалтын санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, түүнийг мөнгөжүүлэх, эргэн төлүүлэхтэй холбогдсон асуудлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголбанк, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК, “Монголын ноос, ноолуурын холбоо” ТББ, Үндэсний үйлдвэр, Арилжааны банкууд хамтран ажиллаж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “Голомт банк”, “Ханбогд кашимер” ХХК болон “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн хооронд 2025 оны 06

дугаар сарын 23-ны өдрийн 250623/06-573/974 дугаартай 7 тэрбум төгрөгийн “Ноолуурын худалдан авалтыг дэмжиж, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх дөрвөлсөн гэрээ”-г, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “Голомт банк”, “Говь” ХК болон “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн хооронд 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 250623/06-574 дугаартай **7 тэрбум төгрөгийн** “Ноолуурын худалдан авалтыг дэмжиж, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх дөрвөлсөн гэрээ” болон 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 250623/06-574-1 дугаартай боловсруулах үйлдвэрээс самнасан ноолуур худалдан авах тухай дөрвөлсөн гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулан эцэслэж, талууд гарын үсэг зурж баталгаажууллаа.

Хөдөө аж ахуйн бирж нь тус арга хэмжээнд векселиэр худалдан авсан ноолуурын баталгаажуулалт, бүртгэлд хяналт тавих үүргээр оролцсон бөгөөд “Говь” ХК-ийн худалдан авсан ноолуурт хяналт тавьж, баталгаажуулалтыг гэрээний хавсралт маягтын дагуу гүйцэтгэн Голомт банк руу эх хувиар хүргүүлэн ажилласан. Векселийн эргэн төлөлт гэрээнд заасан хугацаандаа бүрэн төлөгдөж дууссан.

“Ноолуурын худалдан авалтыг дэмжиж, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх дөрвөлсөн гэрээ”



Итгэмжлэгдсэн этгээдийн тоо, 2020-2025

	2020	2021	2022	2023	2024	2025
Итгэмжлэгдсэн агуулах (Улаанбаатар)	16	14	18	23	25	20
Итгэмжлэгдсэн агуулах (орон нутаг)	2	3	106	118	118	4
Итгэмжлэгдсэн тээвэрлэгч	-	-	-	-	-	-
Нийт итгэмжлэгдсэн этгээд	18	17	124	141	143	24

1.1.5 Санхүүгийн тайлангийн хураангуй

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024	2025-09-30
ХӨРӨНГӨ						
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	291.70	1,808.64	949.55	4,460.35	424.77	1,505.97
Дансны авлага	641.85	2,174.53	2,027.58	2,090.81	2,173.64	2,971.41
Татвар, НДШ-ийн авлага	42.17	84.57	84.57	-	-	2.72
Бусад авлага	10.14	16.71	17.54	17.47	17.04	-
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	-	-	-	-
Бараа материал	9.26	14.83	7.97	11.91	42.82	3.01
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,492.63	164.48	73.96	37.16	-	94.62
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-	-	-	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	2,487.74	4,263.76	3,161.18	6,617.71	2,658.27	4,577.73
Үндсэн хөрөнгө	1,664.01	2,007.26	1,998.12	1,814.87	1,917.02	1,719.63
Биет бус хөрөнгө /программ хангамж/	88.00	1,705.14	1,509.11	1,450.67	1,243.82	1,105.59
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-	-	-	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,752.01	3,712.40	3,507.22	3,265.54	3,160.84	2,825.23
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,239.76	7,976.16	6,668.40	9,883.25	5,819.11	7,402.96
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ						
Дансны өглөг	85.02	174.35	-	16.81	117.43	855.37
Цалингийн өглөг	1.61	-	-	-	-	-
Татварын өр	25.49	451.06	184.30	553.06	290.03	404.34
НДШ-ийн өглөг	0.02	-	-	-	-	-
Богино хугацаат зээл	-	-	-	-	-	-
Хүүний өглөг	-	-	-	-	-	-
Ногдол ашгийн өглөг	543.27	-	-	-	-	-
Урьдчилж орсон орлого	-	-	-	-	-	-
Нөөц/Өр төлбөр/	-	-	-	-	-	-
Богино хугацаат өр төлбөр	-	-	-	-	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-	-	-	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	5.40	0.90	3.90	0.90	0.90	0.9
Богино хугацаат өр төлбөрийн дүн	660.82	626.31	188.20	570.76	408.36	1,260.61
Урт хугацаат зээл	-	-	-	-	-	-
Нөөц /Өр төлбөр/	-	-	-	-	-	-

Хойшлогдсон татварын өр	-	-	-	-	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-	-	-	-	-
Болзошгүй өр төлбөр	-	-	-	-	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-	-	-	-	-
Өр төлбөрийн нийт дүн	660.82	626.31	188.20	570.76	408.36	1,260.61
Эздийн өмч						
Энгийн хувьцаа-Төрийн	1,021.70	1,021.70	1,021.70	1,021.70	1,021.70	1,021.70
Эздийн өмчийн бусад хэсэг	0.01	0.01	0.01	0.01	0.01	0.01
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	3.49	3.49
Хуримтлагдсан ашиг	2,557.22	6,328.15	5,458.49	8,290.78	4,385.55	5,117.16
Эзэмшигчдийн өмчийн дүн	3,578.93	7,349.86	6,480.20	9,312.49	5,410.75	6,142.35
НИЙТ ЭХ ҮҮСВЭР	4,239.76	7,976.16	6,668.40	9,883.25	5,819.11	7,402.96

2 ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

2.1 САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Манай Улсын эдийн засагт хөдөө аж ахуйн салбар нь чухал байр суурь эзэлдэг. Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг хангаж байна.

Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг, оны үнээр /тэрбум төгрөг/

	2020	2021	2022	2023	2024
Нийт ХАА-Бүгд	4 856.1	5 733.3	7015.7	6988.2	5 881.1
Газар тариалан	370.7	577.9	634.9	816.4	945.6
Мал аж ахуй	4 469.9	5 118.3	6 336.3	6 124.5	4 883.0
ХАА-н бусад	15.5	37.1	44.5	47.3	52.5

Эх сурвалж: ҮСХ

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий оны үнээрх өсөлтийг салбараар авч үзвэл, үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртөг 2024 онд өмнөх оноос 10.5 хувь, үйлчилгээний салбарынх 23.7 хувь, бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ 23.3 хувиар нэмэгдэж, харин хөдөө аж ахуйн салбарынх 15.8 хувиар буурчээ. ДНБ (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2024 онд 40.3 хувь (уул уурхай, олборлолтын салбарынх 27.9 хувь, өмнөх оноос 0.8 нэгж хувиар буурсан) болж, өмнөх оноос 1.3 нэгж хувиар буурч, хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь 7.3 болж, өмнөх оноос 2.5 нэгж хувиар тус тус буурч, үйлчилгээний салбарын эзлэх хувь 52.4 болж, өмнөх оноос 3.9 нэгж хувиар нэмэгджээ.

Хөдөө аж ахуйн салбар нь 2024 онд 5.9 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.1 (15.8 хувь) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд мал аж ахуйн салбар 1.2 (20.3 хувь) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ. Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь 7.3 болж, өмнөх оноос 2.5 нэгж хувиар буурав. Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 2015 оны зэрэгцүүлэх үнээр 2024 онд 2.8 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.1 (28.7 хувь) их наяд төгрөгөөр буурсан байна.

Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг, 2015 оны зэрэгцүүлсэн үнээр /тэрбум төгрөг/

	2020	2021	2022	2023	2024
Нийт ХАА-Бүгд	4 018.7	3 796.3	4 252.4	3 873.3	2 761.1
Газар тариалан	279.8	356.5	315.7	341.1	378.8
Мал аж ахуй	3 727.0	3 425.7	3 921.9	3 517.2	2 366.1
ХАА-н бусад	11.9	14.1	14.8	15.0	16.2

Эх сурвалж: ҮСХ

Мал аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 2.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 32.7 хувиар буурлаа. Уг бууралтад бойжуулсан төл 16.2 сая

толгой болж, өмнөх оноос 2.1 (11.4 хувь) сая толгойгоор буурсан, зүй бусаар хорогдсон том мал 9.4 сая толгой болж, өмнөх оноос 4.4 (1.9 дахин) сая толгойгоор нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Ургац хураалт /мянган тонн/

	2020	2021	2022	2023	2024
Үр тариа	430.3	614.5	428.6	470.3	443.2
Төмс	244.3	182.6	214.0	179.4	251.4
Хүнсний ногоо	121.2	121.7	148.9	208.4	282.3
Таримал тэжээл	182.1	293.7	171.2	258.2	259.2

Эх сурвалж: ҮСХ

Газар тариалангийн салбарын үйлдвэрлэл тогтворгүй хэвээр байна. Уг салбарын үйлдвэрлэл 2022 онд өмнөх оноос 11.5 хувиар буурсан бол 2023 онд 8.0 хувиар өсжээ. Хураасан үр тариа 2024 онд 443.2 мянган тонн болж, өмнөх оноос 27.2 (5.8 хувь) мянган тонноор буурч, хүнсний ногоо 282.3 мянган тонн болж, өмнөх оноос 73.9 (35.5 хувь) мянган тонноор, хураан авсан төмс 251.4 мянган тонн болсон нь өмнөх оноос 72.0 (40.2 хувь) мянган тонноор нэмэгдсэн байна.

2.1.1 Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт

Хөдөө аж ахуйн гаралтай гол нэрийн бүтээгдэхүүн, түүхий эдийн экспорт 2024 онд 783.81 сая ам.доллар болж нийт экспортын орлогын 5 хувийг эзэлж байна. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний нийт экспорт өмнөх оноос 193.8 сая ам.доллар буюу 24.7 хувиар буурсан байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн экспорт /сая ам.доллар/

	2020	2021	2022	2023	2024
Нийт экспорт - Бүгд	7,576.30	9,241.10	12,538.60	15,186.90	15,783.4
ХАА-Н ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН	421.69	556.77	682.72	977.60	783.81
Мал, амьтад тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн	52.91	42.27	65.26	200.07	197.55
Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	11.09	89.31	99.74	160.74	73.01
Мал, амьтан болон ургамлын гаралтай өөх, тос	0.62	0.98	2.61	3.20	2.55
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	70.21	47.08	23.71	157.72	103.33
Түүхий болон боловсруулсан арьс шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	7.43	6.48	5.24	4.75	3.30
Нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүн	279.48	370.66	486.16	451.15	404.07

Эх сурвалж: ГЕГ

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт өмнөх оноос буурахад мал, амьтад тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний экспорт 2.5 сая ам.доллараар, ургамлын гаралтай бүтээгдэхүүний экспорт 87.3 сая ам.доллараар, мал, амьтан болон ургамлын гаралтай өөх, тосны экспорт 0.6 сая ам.доллараар, хүнсний бэлэн бүтээгдэхүүний экспорт 54.9 сая ам.доллараар, түүхий болон боловсруулсан арьс шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэлийн экспорт 1.5 сая ам.доллараар, нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүний экспорт 47 сая ам.доллараар тус бүр буурсан байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын 51.6 хувийг нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүн, 25.2 хувийг мал, амьтад тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн, 13.2 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 9.3 хувийг ургамлын гаралтай бүтээгдэхүүн, 0.4 хувийг түүхий болон боловсруулсан арьс шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл, үлдсэн 0.3 хувийг мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх эзэлж байна.

Хөдөө аж ахуйн биржээр арилжих барааны жагсаалтад орсон
8 бүлэг бараа, түүхий эдийн экспортын хэмжээ

Д/д	Бараа	Нэр, төрөл	2023 он /экспорт/			2024 он /экспорт/		
			Бирж	Гааль	Зөрүү	Бирж	Гааль	Зөрүү
			Хэмжээ /тн/	Хэмжээ /тн/	Хэмжээ /тн/	Хэмжээ /тн/	Хэмжээ /тн/	Хэмжээ /тн/
1	Ноолуур	Самнасан	739	986	247	493	675	182
		Угаасан	4,499	5,346	847	4,380	4,736	356
		Боловсруулаагүй	81	-	(81)	-	-	-
Нийт			5,319	6,332	1,013	4,872	5,411	538
2	Хонины ноос	Угаасан	10,106	13,093	2,987	6,640	8,183	1,543
		Самнасан	276	377	102	132	134	2
		Боловсруулаагүй	-	-	-	-	-	-
Нийт			10,381	13,470	3,089	6,772	8,317	1,545
3	Тэмээний ноос	Угаасан	948	2	(946)	1,020	1,143	123
		Самнасан	10	42	31	-	6	6
		Боловсруулаагүй	-	-	-	-	-	-
Нийт			958	43	(915)	1,020	1,149	130
4	Ямааны завод ноос	Бараан, цайвар	2,450	2,785	335	3,434	3,687	253
5	Хонины завод ноос	Бараан, цайвар	85		(85)	26	-	(26)
Нийт			2,535	2,785	250	3,461	3,687	226

6	Бодын хөөвөр	Самнасан /сарлагийн/	4	6	2	-	-	-
7	Бодын хөөвөр	Угаасан /сарлагийн/	1	-	(1)	-	26	26
Нийт			6	6	0	-	26	26
8	Арьс шир /дм²/	Боловсруулаагүй	4	336	332	-	40	40
9	Арьс шир /дм²/	Боловсруулсан /ямаа/	-	58,735	58,735	-	52,937	52,937
Нийт			4	59,072	59,067	-	52,977	52,977
10	Тосны ургамал	Шар, хар	21	73,530	73,509	4,422	76,133	76,129
11	Амьд мал /толгой/		-	173	173	-	54	54
12	Мах		-	45,869	45,869	-	47,712	47,712
13	Малын тэжээл		-	-	-	-	-	-
Нийт дүн			19,225	201,280	182,056	16,129	195,467	179,338

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын дэлгэрэнгүй экспортын мэдээ
Хөдөө аж ахуйн биржийн арилжааны мэдээ

2024 онд нийт 675 тонн (228.98 тэрбум төг) самнасан ноолуурыг экспортлосноос Хөдөө аж ахуйн биржээр 493 тонн (128.2 тэрбум төг) буюу экспортод гарсан нийт самнасан ноолуурын 73 хувийг арилжсан. Нийт 4,736 тонн (862.7 тэрбум төг) угаасан ноолуурыг экспортлосноос Хөдөө аж ахуйн биржээр 4,380 тонн (783.7 тэрбум төг) буюу угаасан ноолуурын 92.5 хувийг арилжсан. 2024 онд боловсруулаагүй түүхий ноолуур экспортлоогүй. 2024 онд нийт экспортоор гарсан ноолуурын 90 хувь нь Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцон гарсан байна.

Хонины нийт 8,183 тонн (30.1 тэрбум төг) угаасан ноос экспортлосноос Хөдөө аж ахуйн биржээр 6,640 тонн (13.4 тэрбум төг) буюу экспортод гарсан нийт угаасан ноосны 81.1 хувийг арилжсан. Хонины нийт 134 тонн (1.5 тэрбум төг) самнасан ноосны экспортлосноос Хөдөө аж ахуйн биржээр 132 тонн (409.7 сая) буюу самнасан ноосны 98.5 хувийг арилжсан. 2024 онд боловсруулаагүй хонины ноос экспортлоогүй. 2024 онд нийт экспортоор гарсан хонины ноосны 81.4 хувь нь Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцон экспортод гарсан байна.

Тэмээний нийт 1,143 тонн (12.7 тэрбум төг) угаасан ноос экспортлосноос Хөдөө аж ахуйн биржээр 1,020 тонн (12.3 тэрбум төг) буюу экспортод гарсан нийт угаасан ноосны 89.2 хувийг арилжсан. 2024 онд 6 тонн (713 сая төг) тэмээний самнасан ноосыг экспортлосон хэдий ч эдгээр нь Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд ороогүй байна. 2024 онд нийт экспортоор гарсан тэмээний ноосны 88.8 хувь нь Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцон экспортод гарсан байна.

Ямааны нийт 3,684 тонн (60 тэрбум төг) завод ноос экспортлосноос Хөдөө аж ахуйн биржээр 3,434 тонн (72.8 тэрбум төг) буюу экспортод гарсан нийт ямааны завод ноосны 93.2 хувийг арилжсан. 2024 онд 26 тонн (29 сая төг) хонины завод ноосыг Хөдөө аж ахуйн биржээр арилжжээ. Нийт завод ноосны 93.8 хувь нь Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцон экспортод гарчээ. Бодын хөөвөр самнасан, угаасан хэлбэрээр Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцоогүй байна.

2024 онд 40,101м² (338.0 сая төг) боловсруулаагүй арьс шир, 52,937,310 дм² (4.6 тэрбум.төг) боловсруулсан арьс ширийг экспортолсон байх ба эдгээрийг Хөдөө аж ахуйн биржээр арилжаагүй байна.

2024 онд 76,133 тонн тосны ургамал экспортлосноос Хөдөө аж ахуйн биржээр 4,422 тонн буюу 5.8 хувийг арилжсан байна.

Мөн 2024 онд 54 мян.толгой амьд мал, 47,712 тонн мах экспортод гарчээ.

2.1.2 Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний импорт

Монгол Улсын 2024 онд нийт 11,612.5 сая ам.долларын бараа, түүхий эдийг импортлосон нь 2023 оны мөн үетэй харьцуулахад 2,362.2 сая ам.доллараар буюу 25.5 хувиар өссөн байна. Хөдөө аж ахуйн гаралтай гол нэрийн бүтээгдэхүүн, түүхий эдийн импорт 2024 онд 1,409.3 сая ам.доллар буюу нийт импортын 12.1 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 210.8 сая ам.доллар буюу 15 хувиар өссөн байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний импорт /сая ам.доллар/

	2020	2021	2022	2023	2024
Нийт импорт - Бүгд	5,293.9	6,848.6	8,704.4	9,250.3	11,612.5
ХАА-Н ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН	758.9	1,073.0	1,271.1	1,198.5	1,409.3
Мал, амьтад тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн	77.7	121.5	142.1	149.8	149
Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	120.2	187.6	145.3	153.3	205
Мал, амьтан болон ургамлын гаралтай өөх, тос	35.8	46.5	59.6	36.8	41.6
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	434.4	607.2	781.3	698.4	864
Түүхий болон боловсруулсан арьс шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	5.0	6.4	9.3	9.5	9.8
Нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүн	85.8	103.8	133.9	150.7	139

Эх сурвалж: ГЕГ

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний импорт 2024 онд өмнөх оноос өсөхөд, ургамлын гаралтай бүтээгдэхүүний импорт 51.7 сая ам.доллар буюу 25.2 хувиар, мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөхний импорт 4.8 сая ам.доллар буюу 11.7 хувиар, хүнсний бүтээгдэхүүний импорт 166 сая ам.доллар буюу 19.3 хувиар, түүхий болон боловсруулсан арьс шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэлийн импорт өмнөх

оноос 0.3 сая ам.долларар буюу 2.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Мөн нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүний импорт 11.7 сая ам. доллар буюу 8.1 хувиар буурсан байна.

Мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн импорт /мян.ам доллар/

	2023 он		Гаалийн нэгжийн дундаж үнэ	2024 он		Гаалийн нэгжийн дундаж үнэ
	тоо хэмжээ	үнийн дүн		тоо хэмжээ	үнийн дүн	
АМЬД МАЛ, ТОЛГОЙ						
Адуу	333	358.9	1.077	520	680.6	1.308
Үхэр	545	1298	2.4	611	1,475.7	2.4
Хонь, ямаа	44	5	0.113	-	-	-
МАХ, ТОНН						
Үхрийн мах	59	78.9	9	35.1	466.0	13.3
Адууны мах	45.0	102.5	2.8	65.0	233.2	3.6
Дайвар бүтээгдэхүүн	275.8	230.2	0.83	346.3	215.6	0.62
Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	81.5	594.7	7.3	79.4	606.7	7.6
Өлөн гэдэс, давсаг, гүзээ	-	-	-	0.24	0.3	1.24
Малын өөх, тос	56.1	80.3	1.43	6.5	19.6	3
НООС, НООЛУУР, ТОНН						
Сэмлээгүй эсвэл самнаагүй хонины ноос	234.8	638	2.7	188.5	521.7	2.8
Бусад мал амьтны самнасан болон самнаагүй үс, хялгас, Мал амьтны үс, хялгасны хаягдал	564.5	13,342.8	23.6	429.6	8,106.4	18.9
Хонины сэмэлсэн ноосон, жижиглэн баглаагүй ээрмэл	47.8	1,086.3	24.6	80.0	1,104.3	13.8
Мал амьтны нарийн ширхэгт үс, ноосон ээрмэл	23.0	2,089.4	90.9	14.8	1,434.7	97.3
Эсгий /м²/	151.0	200.4	1.3	145.2	257.8	1.7
АРЬС ШИР, МЯН.ШИРХЭГ						
Үхэр, адууны болосруулаагүй шир, хулдаас, мянган ширхэг	0.01	-	-	10.4	22	2.1
Үхэр, адууны боловсруулаагүй шир, сая.дм²	1.0	43.8	0.0	.1	45.2	598.3
Үхэр, адууны боловсруулсан шир, сая.дм²	1,558.5	76.5	0.05	4,527.9	274.1	0.06

Хонь, хурганы боловсруулсан арьс, мян.дм ²	-	-	-	-	-	-
Ямаа, ишигний боловсруулсан арьс, мян.дм ²	-	-	-	297.0	13.9	0.05


Эх сурвалж: ГЕГ

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний импортын 61.4 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 14.5 хувийг ургамлын гаралтай бүтээгдэхүүн, 10.6 хувийг мал, амьтад тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн, 9.8 хувийг нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүн, 2.9 хувийг мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх, үлдсэн 0.8 хувийг түүхий болон боловсруулсан арьс шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл эзэлж байна.

2.1.3 Малын тоо, сүргийн бүтэц

2024 оны жилийн дүнгээр малын тоо толгой 57.6 сая болж, өмнөх оноос 7.0 сая толгойгоор буюу 10.9 хувиар буурсан байгаагаас адуу 4.7 сая, үхэр 5.1 сая, тэмээ 480.6 мянга, хонь 24.5 сая, ямаа 22.9 сая толгой тоологдлоо.

Малын тоо, сая толгой, 2020-2024 он



Эх сурвалж: ҮСХ


Малын тоо, төрөл тус бүрээр

	2020	2021	2022	2023	2024
Адуу	4,093	4,324	4,821	4,829.7	4,881.7
Үхэр	4,732	5,022	5,512.8	5,350.8	5,072.7
Тэмээ	472.9	454	470.46	473.9	480.6
Хонь	30,049	31,087	32,747	29,409	24,487.3
Ямаа	27,720	26,456	27,569	24,618.2	22,914.8
Бүгд	67,068	67,343	71,120	64,681.9	57,637.1

Эх сурвалж: ҮСХ


Малын тооны өөрчлөлтийг төрлөөр авч үзвэл, 2024 онд хонь 4.9 сая (16.7 хувь), адуу 148.0 мянга (3.1 хувь), үхэр 278.0 мянга (5.2 хувь), тэмээ 6.7 мянга (1.4 хувь), ямаа 1.7 сая (6.9 хувь) толгойгоор тус тус буурсан байна.

Сүргийн бүтэц, 2024 он



Эх сурвалж: ҮСХ

Малын тоо, аймаг, нийслэлээр /мян.толгой/



Эх сурвалж: ҮСХ

Малын тоон өөрчлөлт, аймаг, нийслэлээр /мян.толгой/

д/д	Аймаг/нийслэл	2023 он	2024 он	Өөрчлөлт	
				Тоо	Хувь
1	Архангай	4 847.4	4 081.5	- 766.0	-16%
2	Баян-Өлгий	2 046.1	2 124.8	78.7	4%
3	Баянхонгор	4 072.2	4 026.1	- 46.1	-1%
4	Булган	3 622.9	3 038.1	- 584.8	-16%
5	Говь-Алтай	3 013.2	3 094.5	81.3	3%
6	Говьсүмбэр	450.1	289.6	- 160.6	-36%
7	Дархан-Уул	261.3	251.8	- 9.5	-4%
8	Дорноговь	2 294.8	1 451.4	- 843.4	-37%
9	Дорнод	3 151.7	2 649.7	- 502.0	-16%
10	Дундговь	3 661.1	3 384.3	- 276.8	-8%
11	Завхан	3 067.6	3 008.2	- 59.3	-2%
12	Орхон	175.3	175.8	0.5	0%
13	Өвөрхангай	4 734.7	5 137.7	403.0	9%
14	Өмнөговь	2 042.0	1 970.1	- 71.9	-4%
15	Сүхбаатар	3 859.5	2 008.9	-1 850.5	-48%
16	Сэлэнгэ	1 769.4	1 602.2	- 167.2	-9%
17	Төв	4 933.0	4 153.0	- 780.0	-16%
18	Увс	2 994.5	2 934.6	- 59.9	-2%
19	Улаанбаатар	427.2	412.8	- 14.4	-3%
20	Ховд	3 194.9	3 490.2	295.3	9%
21	Хөвсгөл	5 662.0	5 160.5	- 501.5	-9%
22	Хэнтий	4 401.0	3 191.3	-1 209.7	-27%
Нийт		64 681.9	57 637.1	-7 044.8	-10.9%

Эх сурвалж: YCX

Орхон, Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Өвөрхангай аймгуудад малын тоо өмнөх оноос 0.5-403.0 мянгаар өссөн. Дархан-Уул, Баянхонгор, Завхан, Увс, Өмнөговь, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дундговь, Хөвсгөл, Дорнод, Булган, Архангай, Төв, Дорноговь, Хэнтий, Сүхбаатар аймгууд болон Улаанбаатар хотод малын тоо өмнөх оноос 9.5 мянгаас 1.9 саяар буурсан.

Улсын хэмжээнд 2024 онд нийт 16.1 сая төл бойжуулсан байна. Төллөсөн хээлтэгч өмнөх оноос 3.9 сая, бойжсон төл 2.3 сая толгойгоор буурсан байна. 100 эхээс бойжуулсан төл 54 толгой болж, өмнөх оноос 6 төлөөр буурсан байна

Хөвсгөл аймаг 5.2 сая толгой мал тоолуулж, улсад хамгийн их малтай аймгаар, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум 507.9 мянган толгой мал тоолуулж, улсад хамгийн их малтай сумаар тус тус шалгарсан. Архангай аймаг адуу, үхрийн тоогоор, Өмнөговь аймаг тэмээний тоогоор, Өвөрхангай аймаг хонины тоогоор, Баянхонгор аймаг ямааны тоогоор тэргүүлсээр байна.

3 БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуульд Монгол Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн НЭГ л бирж үйл ажиллагаа явуулахыг хуульчилсан байдаг.


3.1 КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн “Төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг тогтоох тухай” 47 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн биржийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр болсон. Хувьцаа эзэмшигчийн эрх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд шилжсэн.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дугаар тушаалаар Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Отгонцэцэг, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Салбарын хяналтын газрын дарга Б.Батшагай, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын туслах О.Баттулга, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 02 дугаар тушаалаар Ерөнхийлөгчийн Тамгын газрын Ахлах реферант П.Баасандулам нарыг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр “Эрдэнэс монгол” ХХК-ийн Захиргаа, хүний нөөцийн газрын Хүний нөөцийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Н.Энхмандах, “Фанга фүүдс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ариунболд, ШУТИС-н Менежментийн сургуулийн Захирал Г.Баттүвшин нарыг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Э.Сугарбаяр нар томилогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор компанийн Гүйцэтгэх захирлаар Х.Отгонбаяр томилогдон ажиллаж байна.

3.1.1 Биржийн бүтэц, зохион байгуулалт



Хэлтсийн чиг үүрэг

■ **Санхүү, удирдлагын хэлтэс** нь биржийн хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүргийн хүрээнд Гүйцэтгэх захирлын ажилд туслах, компанийн санхүү хариуцаж тайлан баланс гаргах, аж ахуйн асуудлыг хариуцах, хүний нөөцийн мэдээлэл судалгаа бүрдүүлэх, хөдөлмөрийн болон бусад төрлийн гэрээг байгуулах, мэдээлэл харилцаа холбоо, бичиг хэрэг, архив, хууль эрх зүйн асуудлыг удирдан зохион байгуулах, биржийн зах зээлийн талаар олон нийтэд мэдлэг, боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулах, төсөл хөтөлбөртэй харилцаа холбоо тогтоох, хамтын ажиллагааг өргөжүүлэх, арилжааны өмнөх болон дараах үеийн клирингийн үйл ажиллагаа, дараах үеийн мөнгөн төлбөр тооцоог банкны системээр дамжуулан гүйцэтгэх, төлбөр тооцооны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд холбогдох журмыг мөрдүүлэх, хяналт тавих, Блокчэйн технологид суурилсан “Арилжаа, төлбөр тооцооны цахим систем”, экспортын баримт бичиг бүрдүүлэлтийн “Экспортын нэг цонхны цахим үйлчилгээний систем”, татварын и-баримтын “Багцын гэрээний систем”, биржийн үйл ажиллагаанд ашиглагдах дэд системүүд болон дотоод сүлжээ, веб хөгжүүлэлт, цахим төлөвлөлт, тайлагнал, хяналтын системийн найдвартай үйл ажиллагааг хангах, сайжруулах, мэдээллийн технологи, маркетингийн асуудлыг эрхэлнэ.

■ **Үйл ажиллагааны хэлтэс** нь компанийн хөгжлийн стратеги, бодлогыг төлөвлөх, биржийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр зах зээлийн багтаамж, эрэлт, нийлүүлэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар судалгаа, шинжилгээ хийх, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг төлөвлөх, үүсмэл санхүүгийн хэрэгслийн болон бусад гэрээг арилжих үндсэн үйл ажиллагааны судалгаа, шинжилгээ хийх, арилжаа зохион байгуулах, арилжаатай холбоотой тайлан мэдээ гаргах, байнгын болон байнгын бус гишүүн оролцогч хоршоо, брокерын компаниудын үйл ажиллагааг зохицуулах, суудлын болон гишүүнчлэлийн эрхүүдийг олгох, хяналт тавих, лаборатори, агуулах, тээврийн байгууллагад итгэмжлэл олгох, биржийн арилжааны зах зээлд оролцогчдыг чадавхжуулах, мэдлэг мэдээлэл олгох асуудлыг эрхэлнэ.

3.2 ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Олон улсын жишигт бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагааг амжилттай авч явах, хөгжүүлэх чухал хүчин зүйлийн нэг бол чадварлаг баг, боловсон хүчин байдаг. Биржийн үйл ажиллагаа нь түүний гишүүд болон харилцагчдад найдвартай үйлчилгээ үзүүлэх чадварлаг хүний нөөц дээр тулгуурлах бөгөөд мэдлэг, туршлагатай хүний нөөцийг эрэлхийлж, тасралтгүй хангагдаж байх нь чухал юм. Биржийн зүгээс энэ салбарт ажиллаж туршлага хуримтлуулсан чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, шинээр чадвар, туршлагатай ажилтан авч ажиллуулахаар зорин хүний нөөцийн бодлогын баримт бичгийг баримтлан ажиллаж байна.

Хүний нөөцийн бодлого нь компанийн эрхэм зорилго, зорилтыг хангаж ажиллахад үйл ажиллагааны онцлог, шаардлагад нийцэх мэргэшсэн чадварлаг хүний нөөцөөр тасралтгүй хангах, нэгэнт бүрдүүлсэн хүний нөөцийн ажлын гүйцэтгэл, сэтгэл ханамжийг дээшлүүлэх, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдэнэ.

Компанийн үйл ажиллагааны онцлог, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнөөс үүсч

болох нөхцөл, үр дагаврыг урьдчилан тооцох, хүний нөөцийн зардлыг хэмнэх, цаашид шаардлагатай хүний нөөцийг төлөвлөх, сургаж хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулахаар үндсэн гурван зорилтыг богино, дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлоготой ажиллана. Үүнд:

Зорилт 1. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах, чиг үүргээ хэрэгжүүлэхэд чадварлаг хүний нөөцөөр тасралтгүй хангах зорилтын хүрээнд:

- Компанийн үндсэн чиглэлийн хэлтсүүдийн мэргэжилтнүүдийн орлон ажиллах чадварыг нэмэгдүүлэх;
- Ажлын байр шинээр бий болсон, сул орон тоо гарсан тохиолдолд дотоод эх үүсвэрээс сонгон ажиллуулах. Тухайн албан тушаалд нэр дэвших ажилтан байхгүй тохиолдолд гадаад эх үүсвэрийг ашиглах;
- Үндсэн чиг үүргийн албадын мэргэжилтнүүдийн нөөц бүрдүүлэлтийг дотоодын их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт биржийн үйл ажиллагааны талаар оруулах, хамтран ажиллах;
- Ижил төстэй байгууллагуудын мэргэшсэн чадварлаг хүний нөөцийн талаар иж бүрэн судалгаатай болох;

Зорилт 2. Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг сайжруулах, сургаж хөгжүүлэх зорилтын хүрээнд:

- Ажилтнуудад байгууллагын эрхэм зорилго, зорилт, үнэт зүйлсийг ухамсарлуулах;
- Шинэ ажилтныг чиглүүлэх, дадлагажуулах;
- Нийт ажилтнуудыг сургаж, хөгжүүлэхэд дотоод нөөц бололцоог ашиглах;
- Ажлын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн сэдэлжүүлэлтийг хийх;
- Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх оновчтой аргачлал боловсруулж, хөгжүүлэх;
- Ажлын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн сэдэлжүүлэлтийг хийх;
- Мэргэшүүлэх чиглэлээр сургалтад хамруулах;
- Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой технологийн дэвшлийг нэвтрүүлэх;

Зорилт 3. Ажилтнуудын нийгмийн халамжийн баталгааг хангах, ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд:

- Ажилтнуудын сэтгэл ханамж, нийгмийн баталгааг хангах;
- Ажилтнуудыг идэвхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулах;
- Байгууллагын нэр хүндийг өсгөх;
- Ажиллах орчин нөхцөл, нийгмийн баталгааг хангах;

3.3 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь 2026 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан компанийн бүтцийн дагуу “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуульд заасны дагуу арилжаа зохион байгуулах, мэргэжлийн оролцогчийн хүрээнд гишүүнчлэл хэрэгжүүлэх болон арилжаатай холбоотой төлбөр тооцоо, ложистикийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана.

3.3.1 Компанийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх

Хөдөө аж ахуйн бирж нь үйл ажиллагааны цар хүрээ, зах зээлээ тэлэх, биржийн оролцогчдын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр 6 бүлэг ажлыг төлөвлөн, бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Эдгээр ажлууд нь биржийн үйл ажиллагаа, хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжил болон улсын эдийн засаг, мөнгөний эргэлтийг дэмжих чухал ач холбогдолтой юм.



Стратеги зорилго 1: Биржийн зах зээлийн зохицуулалт, эрх зүйн орчинг сайжруулах;

Биржийн зах зээлийг боловсронгуй болгох замаар холбогдох хууль, журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал боловсруулах, төрийн бодлого төлөвлөлттэй уялдуулах замаар “Хөдөө аж ахуйн биржийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, биржийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллана.

Мөн биржийн үйл ажиллагаанд хамаарах хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж буй богино, дунд, урт хугацааны төрийн бодлого төлөвлөлт, хөтөлбөрийн уялдаа холбоог хангаж, үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллана.

Хуулийн шинэчилсэн найруулгын онцлог зохицуулалт

Монгол Улсын хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжааг шударга, нээлттэй ил тод зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтоох боломжийг хангах, экспортыг нэгдсэн бодлогоор зохицуулах замаар хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд энэ салбарын оруулах хувь нэмрийг улам өргөжүүлэх, зах зээлд оролцогчдын тоог нэмэгдүүлэх биржийн арилжаа, бүртгэлийн үйл ажиллагаа, мэдээллийн сан бүрдүүлэх нарийвчилсан харилцааг зохицуулна.

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ

ЗОРИЛГО

Хөдөө аж ахуйн биржийн зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тодорхойлох, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэх, бүртгэх, биржийн арилжааг зохион байгуулах, хяналт тавих, оролцогчийн эрх, үүргийг тогтоох болон энэхүү үйл ажиллагаатай холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.

ЗОРИЛТ

Хөдөө аж ахуйн салбарын анхдагч үйлдвэрлэгчид болох малчид, тариаланчид, хоршоодын бэлтгэсэн бараа, түүхий эдийг олон шат дамжлагагүй арилжих, бүртгэлжүүлэх, хэрэглэгч (боловсруулах үйлдвэрлэгч, экспортлогч)-д хүргэх зорилгоор биржийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх үндсийг боловсронгуй болгон тогтоох.


7 Бүлэг

25 Зүйл


ХУУЛИЙН АГУУЛГА, БҮТЭЦ

- I Нийтлэг үндэслэл
- II Хөдөө аж ахуйн бирж, түүний үйл ажиллагаа
- III Биржийн арилжаа
- IV Биржийн бүртгэл, мэдээллийн сан
- V Биржийн арилжаанд оролцогч, түүний эрх үүрэг
- VI Бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт
- VII Биржийн үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх

Хуулийн шинэчлэлийн хүрээнд бий болох биржийн арилжаа, бүртгэлийн схем



Тоо баримтын эх сурвалж: ҮСХ, МХААХҮХ, ХХААХҮЯ



Стратеги зорилго 2: Биржийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;

Биржийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулж, ажлын үр дүнг нэмэгдүүлэх, чадавхжуулах, ажлын гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог бий болгох, санхүү болон эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн, маркетинг, олон нийтийн харилцааг өргөжүүлэх, зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх талаар уялдаа холбоо бүхий цогц ажлуудыг зохион байгуулна.

“Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-т заасны дагуу хүний нөөцийг бүрдүүлэх, мэргэшүүлэх, чадавхжуулах арга хэмжээг авч ажиллана.



Стратеги зорилго 3: Биржийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

Биржийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг тэлэх, гадны ижил төстэй үйл ажиллагаа эрхлэн явуулдаг биржүүдтэй туршлага солилцох, гадаадын таваарын биржүүдийн холбоонд гишүүнээр элсэх, "Хамтран ажиллах санамж бичиг" байгуулсан таваарын биржүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх арга замыг тодорхойлох, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод, төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, судалгаа шинжилгээ, сургалт технологи, хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтарсан хөтөлбөр боловсруулан ажиллана.



Монголын хөдөө аж ахуйн хоршоолгчдын үндэсний холбоо



Монголын ноос, ноолуурын холбоо



Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо



Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо



Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам



Мал эмнэлгийн ерөнхий газар



Ургамал хамгааллын газар



“Хөдөө аж ахуйн корпораци” ХХК



Малын удмын сангийн үндэсний төв



“Эрчист монгол” ХХК



Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим




НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр



Монголын байгалийн өв сан



Гадаад улсын ижил төстэй бирж




Стратеги зорилго 4: *Мэдээлэл технологийн цахим шинэчлэлт хийх;*

“Цахим хөдөө аж ахуй” бодлогын хүрээнд биржийн үйл ажиллагаа, арилжаа, клиринг, төлбөр тооцоо, дэд бүтцэд шаардагдах техник, технологийн системийг хөгжүүлж, цахим шинэчлэлтийг хийнэ.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хаанаас ч биржийн арилжаанд саадгүй оролцох боломж бүхий мэдээллийн технологийн сүлжээнд холбогдсон хөдөө аж ахуйн салбарын зах зээлд оролцогчдийг биржийн спот арилжаанд идэвхтэй оролцуулах, форвард, фьючерсийн арилжааны системийг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

Гэвч компани үйл ажиллагаагаа өргөжүүлж, хөдөө аж ахуйн зах зээлд оролцогчдод бизнесийн эрсдэлээ удирдах үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжих, олон улсын жишигт нийцэж ажиллахад зах зээлд оролцогчдод хүлээн зөвшөөрөгдсөн арилжаа, клиринг-төлбөр тооцооны цогц систем шаардлагатай байгаа бөгөөд одоогийн биржийн ашиглаж буй арилжаа, төлбөр тооцооны блокчэйн технологи энэхүү шаардлагыг хангаж чадахгүй байна.

Иймд Хөдөө аж ахуйн биржээр үүсмэл санхүүгийн хэрэгсэл арилжих бэлтгэл ажлын хүрээнд клиринг, төлбөр тооцооны олон улсын арга, аргачлалыг нэвтрүүлж, оролцогчдын эрсдлийг бууруулах, арилжаа, төлбөр тооцоог эрсдэлгүй гүйцэтгэх, өгөгдөл мэдээлэл солилцох, тооцоолол хийх, үүсмэл санхүүгийн хэрэгсэл арилжих нөхцөлийг бүрдүүлсэн Монгол Улсын онцлогт тохирох олон улсын таваарын биржийн системийг сонгох, нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ авч, олон улсын чиг хандлагад нийцсэн технологийн шинэчлэл хийнэ.



Стратеги зорилго 5: *Биржийн зах зээлд оролцогч руу чиглэсэн тэнцвэртэй бодлого хэрэгжүүлэх;*

Биржийн зах зээлд оролцогчдод тавигдах нөхцөл, шаардлагыг үйл ажиллагааны онцлогтой уялдуулан оновчтой тогтоох, зах зээлийн мэдээ, мэдээллээр хангах, тэдгээрийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх “Шинэ хоршоо хөдөлгөөн”, Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих “Цагаан алт” хөдөлгөөн, “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хүрээнд биржийн арилжааны зах зээлд оролцогч малчин, тариалан эрхлэгч, хоршоо, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч, үр үржүүлэг, тэжээлийн болон гурилын үйлдвэр, агуулах, тээвэр, лабораторийн үйл ажиллагаа эрхлэгч, боловсруулах үйлдвэр, экспортлогч аж ахуйн нэгжүүдэд биржийн үйл ажиллагааг танилцуулах, чадавхжуулах, арилжаанд татан оролцуулах боломжийг тодорхойлон ажиллана.

Үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ



Стратеги зорилго 6: Биржийн дэд бүтцийг сайжруулах;

Биржийн итгэмжлэгдсэн этгээдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах, агуулах, лаборатори, тээвэрлэгч бүхий ложистикийн үйл ажиллагааг сайжруулж, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогын дагуу төрөөс хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд биржээр арилжих бараа, түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээг бүсчлэлээр дамжуулан бүрдүүлэх арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран зохион байгуулна.

Бараа, түүхий эдийн нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулах




Монгол Улс засаг захиргааны нэгжийн хувьд 21 аймаг, 330 сумдад хуваагддаг. Нийслэл Улаанбаатар хот нь хамгийн олон хүн амтай, хамгийн нягт суурьшилтай хот төдийгүй орон нутгийн болон гадаадын дамжин өнгөрөх худалдаа, тээврийн гол төв нь болдог. Манай улсын өнцөг булан бүрээс Улаанбаатар хот руу чиглэсэн ачаа, тээвэр хийгдэж байна.

Аймаг, сумдаас тээвэрлэх ачаа, тээвэр болон авто замын сүлжээ харилцан адилгүй байдгаас ачаа, тээврийг оновчтой зохион байгуулахад шаардлагатай орон зайн болон дэвшилтэт шийдэл гаргах, бараа нийлүүлэлт, түгээлтэд тавих хяналт, дэд бүтэц, орчныг бий болгох зайлшгүй шаардлага урган гардаг.

Өөрөөр хэлбэл, худалдаа, тээврийг мэдээллээр хангах замаар бизнесийн хөгжлийг дэмжих, ачаа тээврийн төлөвлөлтийг илүү оновчтой болгох зорилгоор “Ложистикийн төв”-үүдийг байгуулах хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Иймд бүсчилсэн хөгжлийн бодлогын дагуу түүхий эдийг бэлтгэж, тээвэрлэхэд аймгуудын байршил болон тээвэрлэлтийн сүлжээтэй уялдуулан биржийн үйл ажиллагааг бүсчлэн хэрэгжүүлж, тухайн бүсэд байгуулагдсан агуулахуудыг итгэмжлэн 21 аймагт буй биржийн байнгын бус гишүүн хоршоодтой хамтран ажиллаж, тэдгээрээр дамжуулан ложистикийн сүлжээг хангуулах, бараа, түүхий эдийн мөшгих тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.

Мал аж ахуйн салбарын түүхий эдийн нөөц, /бүсийн хэмжээнд/



Эх сурвалж: Хот хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн үндэсний хороо

4 САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖ

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуульд биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтыг Хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасны дагуу ямааны ноолуур, ноос, амьд мал, хүнсний буудай, тосны ургамал, мах, арьс шир, малын тэжээл, үрийн буудайг биржээр арилжаалах бараа, түүхий эдийн жагсаалтад тус тус оруулан баталсан байдаг.

Бирж 2025 оны байдлаар ноолуур, ноос, амьд мал, мах, арьс шир, хүнсний улаанбуудай, үрийн буудай, тосны ургамлын спот болон форвард гэрээний арилжааг зохион байгуулж байна. Ирэх жилүүдэд биржээр арилжих барааны жагсаалтад багтсан бусад бараа, түүхий эдийн арилжааг идэвхжүүлэх, мөн биржийн барааны жагсаалтад шинээр бараа, түүхий эд нэмж оруулах, бусад гэрээний арилжааг нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Хүнсний буудай, үрийн буудай, амьд малын худалдаа бүхэлдээ дотоодын зах зээлд нийлүүлэгддэг бол бусад бараа, түүхий эд дийлэнх нь урд хөрш рүү хагас боловсруулсан хэлбэрээр экспортлогдож байна. Салбарын боловсруулах үйлдвэрлэл хангалттай хөгжөөгүй нь нэг худалдагч, нэг худалдан авагчтай мэт өрсөлдөөн багатай, худалдаа голлосон зах зээлийг бий болгожээ.

Түүхий эдийн бодит үйлдвэрлэлийн хэмжээ нь малын тоо, тариалалтын хэмжээ, байгаль, цаг уурын нөхцлөөс хамаарна. Нийт зах зээлийн багтаамж, бодит үйлдвэрлэл нь тогтмол бөгөөд дотоодод арилжигддаг хүнсний буудай, амьд малын зах зээлийн хэмжээ инфляцийн түвшнээс, харин экспортод чиглэсэн бусад түүхий эдийн хувьд валютын ханшаас шууд хамаарч байна.

Малын тоо, толгойн өсөлт, 2024-2030 /мян.толгой, таамаглал*/

	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
2024	57,650	4,683	5,074	480	24,491	22,920
2025*	52,675	4,250	4,494	501	22,180	21,248
2026*	58,790	4,762	5,035	470	24,792	23,728
2027*	59,131	4,802	5,075	465	24,939	23,848
2028*	59,472	4,838	5,119	460	25,086	23,968
2029*	59,750	4,880	5,094	454	25,232	24,087
2030*	60,189	4,941	5,211	449	25,380	24,208

Эх сурвалж: ҮСХ-ны 1970-2024 оны малын тоог Forecase Функци ашиглан таамаглав.

Эдийн засгийн эргэлтэд оруулах малын тоо, 2024-2030 /толгой, таамаглал*/

	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
2024	11,018	702	761	72	4,898	4,258

2025*	10,073	638	674	75	4,436	4,250
2026*	11,244	714	755	71	4,958	4,746
2027*	11,309	720	761	70	4,988	4,770
2028*	11,373	726	768	69	5,017	4,794
2029*	11,428	732	764	68	5,047	4,818
2030*	11,508	741	782	67	5,076	4,842

Эдийн засгийн эргэлтэд оруулах малын тоог таамаглахдаа Forecase Функц ашиглан таамаглан гаргасан малын тооноос бод малыг 15 хувь, бог малыг 20 хувь байхаар тооцов.

Зах зээлийн таамаглалыг хийхдээ тухайн зах зээлийн онцлогт тохируулан шугаман загвар ашиглах бөгөөд дараах нөхцөлүүдийг тавьсан болно. Үүнд:

- Таамагласан нийт үйлдвэрлэлийн хэмжээ болон түүхий эдийн үнэ урвуу хамааралтай.
- Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн бодит хэмжээ жил бүр тогтмол хувиар өсдөг ба биржээр арилжаалах хэмжээ тогтмол байна. Учир нь дотоодын үйлдвэрлэл жил бүр мөн хэмжээгээр өсдөг.

(Шугаман загвар гэдэг нь $Y = b_1 \cdot x + b_2$ тооцооллын үр дүн хугацааны нэг үе тутам тогтмол b_1 коэффициентээр өөрчлөгддөг загвар).

Зах зээлийн нийт хэмжээг бодох загвар

$$Q = 0.7 Q_{(-1)} + 0.2 Q_{(-2)} + 0.1 Q_{(-3)}$$

Q – ирэх жилийн түүхий эдийн хэмжээ

$Q_{(-t)}$ – сүүлийн t дэх жилийн түүхий эдийн хэмжээ

Зах зээлийн нийт хэмжээг бодох шугаман загвар нь тухайн жилийн арилжааны дүнд жилийн өмнөх зах зээлийн нийт дүн 0.7, хоёр жилийн өмнөх дүн 0.2, гурван жилийн өмнөх дүн 0.1 коэффициентээр нөлөөлөх юм.

Бараа, түүхий эдийн үнэ бодох загвар

Түүхий эдийн үнэ зөвхөн инфляцийн түвшнээс хамаарна.

$$P = (1+i) (0.7 P_{(-1)} + 0.2 P_{(-2)} + 0.1 P_{(-3)})$$

P – ирэх жилийн түүхий эдийн үнэ

i – ирэх жилийн инфляцийн түвшин $P_{(-t)}$ – сүүлийн t дэх жилийн үнэ

Инфляцийн түвшиний тухайд Монгол банкны инфляцийн түвшинг тооцсон төсөөллийг ашиглаж бараа, түүхий эдийн үнийг тооцооллоо.

Малын гаралтай бараа, түүхий эдийн хувьд гарц хэмжээ нь малын тоо хэмжээнээс шууд хамаардаг. Малаас гарах ноос, ноолуурын гарцыг тодорхойлохдоо **1 хониноос 1.3 кг, 1 тэмээнээс 4 кг ноос, 1 ямаанаас 0.31 кг ноолуур** гарахаар дунджаар тооцдог. Мөн гулуузны жингийн гарцаар **1 адуунаас 154 кг мах, 1 үхэрнээс 182 кг мах, 1 хониноос 23.5 кг мах, 1 ямаанаас 14.8 кг мах, 1 тэмээнээс 305 кг мах** гарахаар дунджаар тооцдог.

Нэг жилд бэлтгэгддэг нийт ямааны ноолуурын 10 хүрэхгүй хувийг дотоодын үйлдвэрүүдэд боловсруулан бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бол бусдыг нь үйлдвэрийн аргаар угааж, самнаж, биржийн арилжаагаар дамжуулан экспортод гаргадаг.

4.1.1 Зорилтот зах зээл, таамаглал

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуульд биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтыг Хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасны дагуу Үйлдвэр, Хөдөө аж ахуйн сайдын 2013 оны А/35 дугаар тушаалаар ноолуур, ноос, А/135 дугаар тушаалаар амьд мал, хүнсний буудай, тосны ургамал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-409 дүгээр тушаалаар мах, арьс ширийг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/668 дугаар тушаалаар биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтад малын тэжээл болон үрийн улаанбуудайг нэмж жагсаалтад оруулан баталсан биржээр арилжаалах бараа түүхий эдийн жагсаалтад оруулсан байдаг.

Бирж 2024 оны байдлаар ноолуур, ноос, амьд мал, мах, арьс шир, үр тарианы төрлийн бараа, түүхий эдийн спот гэрээний арилжааг зохион байгуулж байна. Ирэх жилүүдэд эдгээр бараа, түүхий эдийн форвард гэрээг, цаашлаад фьючерс гэрээг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Манай улсад одоогоор фьючерсийн гэрээний арилжаа аль ч биржийн зах зээлд хийгдээгүй байгаа бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос тус гэрээний арилжааны зохицуулалттай зах зээлийг хэрэгжүүлэх нөхцөл, шалгуурыг судлаж байгаа билээ. Биржийн технологийн шинэчлэлт хийгдсэнээр үүсмэл санхүүгийн хэрэгсэлийн арилжааг зохион байгуулах боломж бүрдэнэ.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн зах зээлд өрсөлдөх давуу тал нь олон улсын чиг хандлага бүхий таваарын бирж болж зохион байгуулалт, технологийн шинэчлэл хийж арилжих бараа, түүхий эд болон гэрээний төрлийг нэмэгдүүлэх явдал юм. Мөн гадны ижил төстэй үйл ажиллагаа эрхлэн явуулдаг биржүүдтэй туршлага солилцох, гадаадын таваарын биржүүдийн холбоонд гишүүнээр элсэж биржийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг тэлэх, биржийн арилжааны зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх, бараа, түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээг бүсчлэлээр дамжуулан бүрдүүлэх арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Спот гэрээний арилжааны таамаглал

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоолоор “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг баталсан бөгөөд тус тогтоолыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Хөдөө аж ахуйн биржээр ямааны самнасан ноолуурын арилжааг зохион байгуулж байна.

2025 оноос сэлгээнд тариалах тосны ургамлын дотоодын болон импортын үрийг Хөдөө аж ахуйн биржийн бүртгэлийн арилжаанд оролцон тариалах, хураасан ургацаас дотоодын үйлдвэрт нийлүүлэх болон экспортлох арилжааг биржээр дамжуулан арилжина.

Ямааны ноолуур, хонь болон тэмээний ноосны хувьд биржээр тодорхой хугацаанд арилжиж ирсэн тул зах зээлийн хандлага харьцангуй тогтворжсон гэж үзээд зорилтот арилжааны дүнг тооцохдоо зах зээлийн багтаамж, болон биржийн арилжааны сүүлийн 3 жилийн дундаж дээр тулгуурлан таамаглав.

Спот гэрээний арилжааны дүнг таамаглахдаа ноолуур, ноос, тосны ургамлын хувьд биржийн арилжааны мэдээг, харин хангалттай түүхэн өгөгдөлгүй, эсвэл шинээр арилжих гэж буй хүнсний буудай, үрийн буудай, мал, мах, арьс шир, малын тэжээл зэрэг бараа, түүхий эдийн хувьд холбогдох төрийн байгууллагуудын бэлтгэдэг мэдээг ашиглан тооцсон болно.

Спот гэрээгээр арилжих бараа, түүхий эдийн хэмжээ, 2026* /таамаглал/

	Хэмжих нэгж	2022	2023	2024	2025.12.15	2026*
Ямааны ноолуур	тн	7,788.9	6,300.0	5,840.6	3,126	2,980.0
Хонины ноос	тн	15,526.6	10,554.4	6,392.0	3,848.4	6,610.0
Тэмээний ноос	тн	1,692.4	986.8	1,020.6	987.5	980.0
Ямааны завод ноос	тн	1,787.8	2,379.1	3,400.7	1,798	2,400.0
Хонины завод ноос	тн	17.9	67.8	26.5	-	31.4
Тосны ургамал	тн	4,990.0	22,321.0	4,422.0	5,849.0	9,600.0
Хүнсний улаанбуудай	тн	-	100.0	778.0	95,209.12	29,500.0
Үрийн буудай	тн	-	-	1,066.0	12,011.3	10,800.0
Арьс шир	ш		4,400	-	4,825	1,500.0
Мах	тн	-	-	1,892.3	96	50.0
Мал /бог/	толгой	20	2,041	34,744	2,063	2,000.0
Мал /бод/	толгой	-	-	-	79	
Малын тэжээл	тн	-	-	-	14	10.0

Биржээр арилжих спот гэрээний дүн, 2026* /тэрбум төгрөг, таамаглал/

	Хэмжих нэгж	2022	2023	2024	2025.12.15	2026*
Ямааны ноолуур	тн	984.9	838.2	889.7	924.3	870.16
Хонины ноос	тн	25.6	16.2	13.8	8.7	13.42
Тэмээний ноос	тн	14.1	7.9	12.6	14.6	11.57
Ямааны завод ноос	тн	38.2	47.8	71.3	38.2	51.0
Хонины завод ноос	тн	0.21	0.1	0.3	-	0.04

Тосны ургамал	тн	7.5	30.7	7.6	9.9	16.22
Хүнсний улаанбуудай	тн	-	-	0.5	94.7	36.0
Үрийн буудай	тн	-	-	1.7	19.0	16.2
Арьс шир	ш		0.04	-	0.1	0.006
Мал, мах	тн	-	0.25	20.3	1.5	0.915
Малын тэжээл	тн	-	-	-	0.025	10.0

4.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН БҮТЭЦ, ТААМАГЛАЛ

Биржийн үйл ажиллагааны орлогын дийлэнх хэсэг буюу 90 гаруй хувийг арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн орлого дангаараа бүрдүүлдэг бөгөөд гишүүнчлэлийн хураамж, “Хөдөө аж ахуйн биржээр арилжсан бараа, түүхий эдийн тодорхойлолт”-ын хөлс, агуулахын итгэмжлэлийн хураамж, дэд системүүдийн ашиглалтын төлбөр зэрэг үйл ажиллагааны орлого зэрэг бусад нэмэлт орлого нь биржийн орлогын дүнд багахан хувь эзэлдэг.

Биржээр арилжих бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт улирлын чанартай байдгаас хамааран биржийн жилийн орлогын 70-80 хувь нь эхний хагас жилд төвлөрдөг. Гэвч зардлын хувьд арилжааны дүнгээс үл хамаарсан, тогтмол шинжтэй зардлууд байдаг тул жилийн сүүлийн хагаст үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх орлогын эх үүсвэр дутагдах магадлалтай байдаг.

4.2.1 Арилжааны шимтгэл, орлогын төлөвлөлт

Ямааны ноолуурын хувьд зах зээлийн багтаамжийн 90 гаруй хувийг биржээр арилжиж байгаа. Ямааны боловсруулсан ноолуурыг улсын хилээр нэвтрүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоолоор батлагдсан “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдааны техникийн зохицуулалт”-ыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбогдуулан биржээр арилжих самнасан ноолуурын арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээг 0.62 хувь болгон бууруулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 17 дугаар тогтоолыг батлуулсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 31 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд улсын нөөцөд худалдан авах болон гурилын үйлдвэрүүдэд нийлүүлэх үрийн болон хүнсний улаанбуудайг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан арилжих бэлтгэл ажлыг хангаж, арилжааг зохион байгуулан ажиллаж байна. Тус хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 21 дүгээр тогтоолоор Хөдөө аж ахуйн биржээр арилжих хүнсний буудайн арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл чөлөөлсөн.

Арилжааны шимтгэлийн орлого нь арилжааны тоо хэмжээ, үнийн дүнгээс хамаардаг бөгөөд шимтгэлийн хувь хэмжээг Төлөөлөн удирдах зөвлөл тогтоодог. Өнгөрсөн жилүүдэд бирж спот гэрээний арилжааг зохион байгуулж ирсэн. Спот арилжааны

шимтгэлийг нийт хэлцлийн үнийн дүнгээс тогтоосон хувиар тооцон авдаг бөгөөд төлөвлөгөөт хугацааны спот арилжааны шимтгэлийг таамаглахдаа өмнөх хэсэгт таамагласан спот арилжааны дүнгээс одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй шимтгэлийн хувь хэмжээгээр тооцон авахаар тооцоолов.

Форвард арилжааны хувьд барааны төрөл, онцлогийг харгалзан гэрээ нээх, хаах үед тогтмол дүнгээр арилжааны шимтгэлийг тооцоолохоор төлөвлөж байна. Өөрөөр хэлбэл, форвард гэрээгээр арилжих барааны төрөл тус бүр дээр гэрээний хамгийн бага нэгжийг тогтоож өгсөн байх бөгөөд тухайн гэрээг худалдах, худалдан авах позици нээх, хаах бүрт тогтмол дүнгээр арилжааны шимтгэлийг тооцоолох ба форвард гэрээний арилжааны шимтгэл нь биржээр арилжихаар таамагласан форвард гэрээний дүнгийн 0.25 хувь болно.

Арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн орлого, 2026* /сая төгрөг, таамаглал/

Үзүүлэлт	2026*
Спот арилжааны таамаглал	962,776.1
Спот арилжааны шимтгэлийн орлого	5,497.2
Спот төлбөр тооцооны шимтгэлийн орлого	192.5
Форвард арилжааны таамаглал	53.1
Форвард арилжааны шимтгэлийн орлого	132.8
Шимтгэлийн нийт орлого	5,824.17

Төсөвлөсөн орлогын дүн, 2026* /сая.төгрөг, таамаглал*/

Үзүүлэлт	2026*
Арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн нийт орлого	5,824.17
Агуулахын итгэмжлэлийн орлого	3.3
Тодорхойлолтын орлого	5.9
Гишүүнчлэлийн хураамж	9.0
Экспортын нэг цонхны системийн хураамж	45.5
Бусад орлого	-
Нийт орлогын дүн	5,887.9

4.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Компани 2026 онд дараах томоохон хөрөнгө оруулалтын ажлыг өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна. Эдгээр нь:

1. Биржийн дунд хугацааны бодлогын баримт бичиг "Стратеги төлөвлөгөө 2027-2031"-г шинэчлэн боловсруулах, батлуулах зөвлөх үйлчилгээ авах;
2. Арилжаа, төлбөр тооцоог эрсдэлгүй гүйцэтгэх, өгөгдөл мэдээлэл солилцох, үүсмэл санхүүгийн хэрэгсэл арилжих нөхцөлийг бүрдүүлсэн Монгол Улсын онцлогт тохирох олон улсын таваарын биржийн системийг сонгох, нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээг авах;

3. “Арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн систем”, “Экспортын нэг цонхны систем”, “Багцын гэрээний систем”, “Агуулах итгэмжлэлийн нэгдсэн систем”, “Ажил гүйцэтгэлийн үнэлгээний систем” болон бусад дотоод үйл ажиллагааны систем ашиглалт, сайжруулалт;
4. Биржийн веб сайт болон өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдаж буй програм хангамж, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа болон сүлжээний найдвартай байдлыг хангах.

4.3.1 2026 оны үйл ажиллагааны төсвийн төсөл

Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны төсөв	2025 оны ХБГ	2026 оны төсвийн төсөл	2026 төсөв/ 2025 төсөв
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
а) АРИЛЖААНЫ ХЭМЖЭЭ	тонн	47,233.90	28,008.00	129,903.32	66,461.40	237%
Ноолуур	тонн	5,863.00	3,000.00	3,126.04	2,980.00	99%
Хонины ноос	тонн	6,340.00	8,257.00	3,219.80	6,610.00	80%
Тэмээний ноос	тонн	1,021.00	934.00	1,616.10	980.00	105%
Ямааны завод ноос	тонн	3,365.00	2,192.00	1,797.96	2,400.00	109%
Хонины завод ноос	тонн	27.00	30.00	-	31.40	105%
Тосны ургамал	тонн	4,422.00	5,495.00	5,849.00	9,600.00	175%
Мал бэлтгэл /толгой/	амьд мал	7,942.00	6,000.00	2,139.00	2,000.00	33%
Мах бэлтгэл /гулууз/	тонн	1,504.90	100.00	96.00	50.00	50%
Үрийн буудай	тонн	1,798.00	1,000.00	12,011.30	10,800.00	1080%
Хүнсний буудай	тонн	14,951.00	1,000.00	95,209.12	29,500.00	2950%
Малын тэжээл	ширхэг	-	-	14.00	1,500.00	0%
Арьс шир	тонн	-	-	4,825.00	10.00	0%
б) АРИЛЖААНЫ ХЭМЖЭЭ	тэрбум.төг	1,029.47	804.19	1,111.26	1,015.53	126%
Ноолуур	тэрбум.төг	889.69	714.00	924.33	870.16	122%
Хонины ноос	тэрбум.төг	13.71	14.99	8.76	13.42	90%
Ямааны завод ноос	тэрбум.төг	71.31	46.69	38.22	51.00	109%
Тэмээний ноос	тэрбум.төг	12.60	8.98	14.69	11.57	129%
Хонины завод ноос	тэрбум.төг	0.03	0.03	-	0.04	131%

Тосны ургамал	тэрбум.төг	7.58	8.90	9.93	16.22	182%
Мал бэлтгэл /толгой/	тэрбум.төг	0.60	0.45	0.40	0.24	53%
Мах бэлтгэл /гулууз/	тэрбум.төг	15.75	7.50	1.10	0.68	9%
Үрийн буудай	тэрбум.төг	2.78	1.50	19.00	16.20	1080%
Хүнсний буудай	тэрбум.төг	15.43	1.15	94.70	35.99	3130%
Малын тэжээл	тэрбум.төг	-	-	0.03	0.01	0%
Арьс шир	тэрбум.төг	-	-	0.10	0.01	0%
НИЙТ ОРЛОГО	мян.төг	6,594,122.25	4,727,839.54	5,614,177.04	5,753,926.34	122%
НИЙТ ЗАРДАЛ	мян.төг	5,665,615.54	4,310,728.70	3,148,063.04	4,897,018.45	114%
Татварын өмнөх ашиг	мян.төг	928,506.71	417,110.84	2,466,114.00	856,907.89	8%
ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)	мян.төг	835,380.25	375,399.76	2,219,502.60	771,217.11	205%
Нийт төсөвт төлөх татвар:	мян.төг	691,816.21	549,749.62	617,244.98	488,364.97	89%
а) Орлогын татвар	мян.төг	93,126.46	41,711.08	246,611.40	85,690.79	205%
б) ХХОАТ	мян.төг	164,322.09	139,865.15	102,665.43	105,278.18	75%
в) ЭМНДШ	мян.төг	434,367.66	368,173.38	267,968.15	297,396.00	81%
Нийт ажиллагсдын тоо		42	24	22	24	100%
Нийт цалингийн сан	мян.төг	1,692,488.49	1,372,760.00	1,155,073.60	1,486,980.00	108%
Ногдол ашиг	мян.төг	417,690.12	187,699.88	417,690.12	1,109,751.30	591%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	мян.төг	360,466.35	19,900.00	19,640.91	32,000.00	161%
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	0.86	0.91	0.56	0.85	93%

5.1 ЭРСДЭЛИЙН ТӨРЛҮҮД

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК байгуулагдсанаас хойш бизнесийн стратегийн хэрэгжилт болон бизнесийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц гадаад, дотоод эрсдэлийн хүчин зүйлсийг удирдах зорилгоор жил болгон Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ирсэн. Биржийн үйл ажиллагааны өнгөрсөн жилүүдийн туршлага болон арилжааны үйл ажиллагааны онцлогоос үзэхэд дараах үндсэн 3 төрлийн эрсдэл учирч болзошгүй байдаг.

1. Стратегийн эрсдэл:

- Бизнес төлөвлөгөө хэрэгжихгүй байх;
- Зах зээлийн өөрчлөлт, нөхцөл байдал нийцэхгүй байх;
- Бизнес өсөлт удаашрах, буурах.

2. Зах зээлийн эрсдэл:

- Арилжааны өмнөх: арилжаанд оролцогч гишүүнчлэлийн шаардлага хангахгүй байх, зах зээлийн талаар буруу мэдээлэл тараах;
- Арилжааны үеийн: үнийн манипулаци, дотоод арилжаа, хуурамч арилжаа гэх мэт;
- Арилжааны дараах: арилжаанд оролцогч гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, төлбөрийн чадваргүй болох.

3. Үйл ажиллагааны эрсдэл:

- Мэдээлэл технологийн: сүлжээ, арилжааны систем болон тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, сүлжээний аюулгүй байдал алдагдах;
- Хүний нөөц: хүний нөөцийн тогтвортой байдал, сургалт, орлон ажиллах байдал алдагдах;
- Аюулгүй байдал: ажлын байр, арилжааны танхим болон мэдээллийн аюулгүй байдал алдагдах;
- Санхүү: үйл ажиллагаа орлого буурах, санхүүгийн хүндрэлд орох.


Өнгөрсөн хугацаанд дээрх эрсдэлүүдээс зах зээлийн эрсдэлийг удирдах зорилгоор арилжааны өмнөх үеийн арилжаанд оролцогчийн агуулахын үлдэгдэл болон дэнчин шалгах, арилжааны үед захиалгын үнийн хязгаар тогтоох зэрэг арга хэмжээг авч ажилласан бол үйл ажиллагааны эрсдэлийг удирдах зорилгоор сүлжээний аюулгүй байдлыг сайжруулах, тоног төхөөрөмж шинэчлэх, хүний нөөцийн хөтөлбөр хэрэгжүүлэх, тогтмол сургалт зохион байгуулах, арилжааны танхимд дохиолол суулгах, санхүүгийн харьцаануудыг тогтмол хянах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

5.2 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлага нь компанийн үйл ажиллагаанд ямар нэгэн байдлаар саад, аюул учруулах бүх төрлийн үйл явдал, үйлдэл, нөхцөл байдлыг урьдчилан таамаглах, урьдчилсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх үйл явц юм.

Биржийн “Эрсдэлийн удирдлагын бодлого 2022-2026” бодлогыг боловсруулан баталсан ба 2017 оноос хэрэгжүүлж эхлэнэ. Эрсдэлийн удирдлагын бодлого нь биржийн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг компанийн зүгээс баримтлах бодлогыг тодорхойлох, учрах эрсдэлүүдийг үнэлэх, ангилах, тухайн төлөвлөгөө хэрэгжих хугацаанд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, хариуцах албан тушаалтан, тайлагналын зарчмыг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын дунд болон урт хугацааны үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бичиг баримт юм.

Эрсдэлийн удирдлагын бүдүүвч



Эрсдэлийн удирдлагын бодлогод биржийн үйл ажиллагаанд нөлөөлж буй эрсдэлүүдийг стратегийн, санхүүгийн, мэдээлэл технологийн, аюулгүй байдлын, хүний нөөцийн, мэдээ мэдээллийн, арилжаа болон дүрэм, журмын гэж ангилан эрсдэл тус бүрд авах арга хэмжээ, харгалзах үнэлгээ, хариуцах албан тушаалтан, хэрэгжилтийг тайлагнах зарчмыг тодорхойлж өгсөн. Эрсдэлийн удирдлагын бодлого нь компанийн бизнес стратегид суурилсан байх бол эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө, бүтэц, журам, стандарт, мониторинг хийгдэнэ.

Бизнес, улс төр, эдийн засаг болон хууль эрх зүйн орчин дахь өөрчлөлтөөс улбаалан шинээр үүсэх эрсдэлийг удирдах, эрсдэлийн удирдлагын шинэ арга барилыг нэвтрүүлэх зэрэг эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийн эрсдэлүүдийн жагсаалтад өөрчлөлт оруулах тохиолдолд Эрсдэлийн удирдлагын хороо санаачлага гаргаж Гүйцэтгэх захирлын тушаалаар шинэчлэн батлах бөгөөд Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, шинэчлэх тохиолдолд зөвхөн төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлын тушаалаар тусад нь батална.

БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ-2026 ОН

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ санал-2026	Хэмжих нэгж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Улирал				Хариуцах нэгж
						I	II	III	IV	
Стратеги төлөвлөгөөний зорилго 1: Биржийн зах зээлийн зохицуулалт, эрх зүйн орчинг сайжруулах										
Дэд зорилт 1.1. Биржийн зах зээлийг боловсронгуй болгох зорилгоор холбогдох хууль, журам, төрийн бодлого төлөвлөлтийн харилцан уялдаа холбоог бий болгоно.										
1.1.1	Биржийн үйл ажиллагаанд хамаарах хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй богино, дунд, урт хугацааны бодлого төлөвлөлт, хөтөлбөр, хөдөлгөөн, төрөөс хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилтийг хангах үе шат бүхий төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллах;	хувь	Баримт бичиг	0%	100%					ҮАХ
Дэд зорилт 1.2. Биржийн үйл ажиллагааны дүрэм, журмыг шинэчлэн найруулж, олон улсад мөрдөгддөг зарчим болон стандартыг өөрийн улсын онцлогт нийцүүлэн										
1.2.1	Биржийн одоогийн мөрдөж буй дүрэм, журмын хэрэгжилтийн үнэлгээг гаргаж, хэрэгжүүлэх боломжгүй болон хэрэгжилт хангалтгүй зүйл, заалтыг тодорхойлон, шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх;	хувь	Баримт бичиг	0%	100%					СУХ
1.2.2	Биржийн дунд хугацааны бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах зөвлөх үйлчилгээ авах, "Стратеги төлөвлөгөө 2027-2031"-г боловсруулан батлуулах;	тоо	Баримт бичиг	0	1					ҮАХ
Дэд зорилт 1.3. "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай" хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.										
1.3.1	"Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай" хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг эцэслэн батлуулах, Монгол Улсын Засгийн газрын гишүүдээс санал авч, Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, батлуулахад өргөн барих эрх бүхий этгээдэд дэмжлэг үзүүлж ажиллах;	тоо	Баримт бичиг	0	1					СУХ, ҮАХ
1.3.2	"Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай" хуулиар хуульчилсан төрийн болон орон нутгийн хөрөнгөөр хийх худалдан авалтын арилжааг биржээр дамжуулан зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд мөрдөгдөх холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, нийцүүлэх, хэрэгжүүлэх;	хувь	Хэрэгжилт	0%	100%					ҮАХ, СУХ
Стратеги төлөвлөгөөний зорилго 2: Биржийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх										
Дэд зорилт 2.1. Биржийн онцлогт тулгуурласан бүтэц зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, бүтцийн шинэчлэл хийж, ажлын үр дүнг нэмэгдүүлнэ.										
2.1.1	Биржийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, шинэчлэх;	хувь	Хэрэгжилт	0%	100%					СУХ
2.1.2	Чанарын менежментийн тогтолцоо, шаардлага ISO 9001 стандартыг судалж, биржийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх;	тоо	Баримт бичиг	0	1					СУХ
Дэд зорилт 2.2. Боловсон хүчний бодлого, төлөвлөлт, нийгмийн оролцоо, хувь хүний хөгжил, цалин урамшуулал, идэвхжүүлэлт бүхий биржийн хүний нөөцийн цогц бодлого, төлөвлөлтийг төсөв болон санхүүгийн төлөвлөгөөнд тулгуурлан 1 болон 5 жилээр боловсруулж, хэрэгжүүлнэ.										
2.2.1	"Хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-т заасны дагуу хүний нөөцийг мэргэшүүлэх, чадавхжуулах, хөгжлийн тогтолцоог боловсронгуй болгох үндсэн бодлогыг баримталж, хувь хүний мэдлэг, туршлага, ур чадварыг үндэслэн хүний нөөцийн сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтууд зохион байгуулах;	тоо	Арга хэмжээ	0	10					СУХ
Дэд зорилт 2.3. Байгууллагын санхүүгийн удирдлага, төлөвлөлт, ашигт ажиллагааг хангаж, хөрөнгө оруулалтын өгөөжийг тогтвортой байлгаж, эрсдэлийн удирдлага, хяналт										

2.3.1	Байгууллагын хөгжлийн зорилго, урт болон богино хугацааны төлөвлөгөөнд үндэслэн зорилтот түвшний төсвийг төлөвлөх, мөнгөн урсгалын менежментийг сайжруулах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх;	хувь	Хэрэгжилт	0%	100%					СУХ
2.3.2	Арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээ, гишүүнчлэлийн хураамж, элсэлтийн хураамж, суудлын хураамж, итгэмжлэгдсэн этгээдийн хураамж болон бусад шимтгэл, хураамжийн хувь, тоо хэмжээг шинэчлэн тогтоох шаардлагатай бол тухай бүр нарийвчлан тооцоолж батлуулах;	хувь	Хэрэгжилт	0%	100%					ҮАХ
Дэд зорилт 2.4. Маркетинг, олон нийтийн харилцааг хөгжүүлнэ.										
2.4.1	Хөдөө аж ахуйн салбарт төрөөс хэрэгжүүлж буй богино, дунд, урт хугацааны бодлого төлөвлөлт, хөтөлбөрдэд биржийн үйл ажиллагаатай холбогдох арга хэмжээг олон нийтэд сурталчлан таниулах, арилжааны зах зээлд оролцогчдод зориулсан “Маркетингийн төлөвлөгөө”-г төсөв болон санхүүгийн төлөвлөгөөнд тулгуурлан жил бүр боловсруулж, батлуулах;	тоо	Баримт бичиг	0	1					СУХ
2.4.2	Биржийн цахим мэдээллийн хэрэгсэл /www.mse.mn/ болон бусад платформ дахь цахим хуудсуудыг хөгжүүлж, олон нийтийн сүлжээнд маркетингийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хөдөө аж ахуйн салбарт төрөөс хэрэгжүүлж буй богино, дунд, урт хугацааны бодлого төлөвлөлт, хөтөлбөрүүдийг сурталчлан таниулах;	тоо	Хэрэгжилт	0	3					СУХ
2.4.3	Хөдөө аж ахуйн салбарт төрөөс хэрэгжүүлж буй богино, дунд, урт хугацааны бодлого төлөвлөлт, хөтөлбөрүүдийг олон нийтэд таниулах сургалт зохион байгуулах, танилцуулга видео, гарын авлага боловсруулах, контент хөгжүүлж, түгээх;	тоо	Хэрэгжилт	0	20					СУХ
2.4.4	Хөдөө аж ахуйн салбарт төрөөс хэрэгжүүлж буй богино, дунд, урт хугацааны бодлого төлөвлөлт, хөтөлбөрүүдийг олон нийтэд таниулах олон нийтэд сурталчлан таниулах, брендинг хийх, мэдээллийг тэгш хүртээмжтэй түгээх;	тоо	Хэрэгжилт	0	200					СУХ
Дэд зорилт 2.5. Биржээр арилжих жагсаалтад орсон бараа, түүхий эдийн арилжааг идэвхжүүлж, шинээр арилжаалах боломжтой бараа, түүхий эдийн нэр төрлийг нэмэгдүүлэн										
2.5.1	Орон нутагт биржээр арилжих барааны жагсаалтад орсон бараа, түүхий эдийн дотоодын арилжаа, дуудлага худалдааг зохион байгуулах;	тоо	Арга хэмжээ	0	6					ҮАХ
2.5.2	“Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ын дагуу бэлтгэсэн “Самнасан ноолуур”-ын арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	2980					ҮАХ
2.5.3	“Хонины ноос”-ны арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	6610					ҮАХ
2.5.4	“Тэмээний ноос”-ны арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	980					ҮАХ
2.5.5	“Ямааны завод ноос”-ны арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	2400					ҮАХ
2.5.6	“Хонины завод ноос”-ны арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	31.4					ҮАХ
2.5.7	“Арьс, шир”-ний арилжааг зохион байгуулах;	ширхэг	Тоо хэмжээ	0	1500					ҮАХ
2.5.8	“Тосны ургамал”-ын арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	9600					ҮАХ
2.5.9	Улсын стратегийн нөөц бүрдүүлэх “Хүнсний улаанбуудай”-н арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	29500					ҮАХ
2.5.10	Сорт, сорилт баталгаажсан “Үрийн улаанбуудай”-н арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	10800					ҮАХ
2.5.11	Биржээр арилжих барааны жагсаалтын “Малын тэжээл” бүлгийн экспортын зориулалттай тэжээлийн арилжааг зохион байгуулах арга замыг тодорхойлж, санал боловсруулан танилцуулах;	хувь	Хэрэгжилт	0%	100%					ҮАХ

2.5.12	Биржээр арилжих барааны жагсаалтын нэр төрлийг нэмэгдүүлэх, шинээр арилжаалах боломжтой бараа, түүхий эдийн судалгааг хийх;	тоо	Баримт бичиг	0	1					YAX
Дэд зорилт 2.6. Биржийн "Гэрээний стандарт"-ыг сайжруулах замаар зах зээлийн хөрвөх чадварыг дээшлүүлнэ.										
2.6.1	Биржээр арилжих барааны жагсаалтад шинэ бараа, түүхий эдийн нэр төрөл нэмэгдсэн тохиолдолд "Спот гэрээний стандарт"-ыг боловсруулж, батлуулах;	хувь	Баримт бичиг	0%	100%					YAX
2.6.2	Биржээр арилжих барааны жагсаалтад орсон бараа, түүхий эдийн "Форвард гэрээний стандарт"-ыг боловсруулж, батлуулах;	тоо	Баримт бичиг	1	8					YAX
Дэд зорилт 2.7. Клиринг, төлбөр тооцооны олон улсын арга, аргачлалыг нэвтрүүлж, оролцогчдын эрсдлийг бууруулах, төлбөр тооцоог эрсдэлгүй түргэн шуурхай гүйцэтгэх										
2.7.1	"Спот гэрээ"-ний арилжаанд цахим гэрээг нэвтрүүлж, төлбөр тооцоог хялбаршуулах, хурдан шуурхай гүйцэтгэх;	хувь	Баримт бичиг	0%	100%					СУХ
2.7.2	"Форвард гэрээ"-ний арилжааны төлбөр тооцоог хялбаршуулах, хурдан шуурхай гүйцэтгэх боломжийг судалж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн сайжруулж боловсруулах;	хувь	Баримт бичиг	0%	100%					СУХ
Дэд зорилт 2.8. Биржийн "Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө"-г боловсруулж, хяналт, мониторингийн тогтолцоог хэрэгжүүлнэ.										
2.8.1	"Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг 2022-2026"-ийн дагуу "Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө"-г жил бүр шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;	хувь	Хэрэгжилт	0%	100%					СУХ
2.8.2	Биржийн зах зээлийн эрсдэлийг тодорхойлж, үнэлэх, урьдчилан таамаглах арга, аргачлал бүхий "Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг 2027-2031"-ийг боловсруулж, батлуулах;	тоо	Баримт бичиг	0	1					СУХ
Стратеги төлөвлөгөөний зорилго 3. Биржийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх										
Дэд зорилт 3.1. Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой харилцан үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.										
3.1.1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харъяа төрийн байгууллагуудтай ажлын уялдаа холбоог сайжруулан хамтран ажиллах;	тоо	Хэрэгжилт	0%	100%					YAX, СУХ
3.1.2	Төрийн байгууллагуудтай ажлын уялдаа холбоог ханган хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтэн, улсын байцаагчдыг чадавхжуулах, мэдээлэл хүргэх хамтарсан сургалт зохион байгуулах;	тоо	Хэрэгжилт	0%	100%					YAX, СУХ
3.1.3	Төрийн бус байгууллагууд, үйлдвэр технологийн паркууд болон мэргэжлийн холбоодтой ажлын уялдаа холбоог ханган хамтын ажиллагааг өргөжүүлэх;	тоо	Хэрэгжилт	0%	100%					YAX, СУХ
Дэд зорилт 3.2. Гадаад болон дотоодод хэрэгжиж буй төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах, бусад орны биржүүдтэй харилцах хамтын ажиллагааг үр ашигтай өргөжүүлнэ.										
3.2.1	Монгол Улсад хэрэгжиж буй гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж биржийн арилжаанд оролцогчдыг чадавхжуулах, биржийн зах зээлийг өргөжүүлэх;	тоо	Арга хэмжээ	0	2					YAX
3.2.2	"Хамтран ажиллах санамж бичиг" байгуулсан гадны ижил төстэй үйл ажиллагаа эрхлэгч таваарын биржүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;	тоо	Арга хэмжээ	0	3					YAX
3.2.3	Ижил төстэй үйл ажиллагаа эрхлэгч таваарын бирж болон үйлдвэр, агуулах, лабораторийн үйл ажиллагаатай танилцах, туршлага солилцох, хамтран ажиллах;	тоо	Арга хэмжээ	0	5					YAX
3.2.4	Ижил төстэй үйл ажиллагаа эрхлэгч олон улсын таваарын биржүүдийн холбоонд элсэж, туршлага солилцох, чадавхжих, гадаад хамтын ажиллагаа, зах зээлээ өргөжүүлэх боломжийг эрэлхийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;	тоо	Арга хэмжээ	0	1					YAX

3.2.5	Монгол Улсаас бэлтгэж буй малын гаралтай бараа, түүхий эдийг худалдан авах сонирхогчдыг тодорхойлох, гадаад зах зээлийн эрэлтийг тооцоолох зорилгоор ижил төстэй үйл ажиллагаа эрхлэгч олон улсын таваарын биржийн арилжааны самбар, веб хуудсанд Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн гарал үүсэл, барааны тодорхойлолт, стандарт болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг байршуулж, тандалт судалгаа хийж, танилцуулах;	тоо	Баримт бичиг	0	1					YAX, СУХ
Стратеги төлөвлөгөөний зорилго 4. Мэдээлэл технологийн цахим шинэчлэлт хийх Дэд зорилт 4.1. Биржийн дотоод үйл ажиллагаа, арилжаа, клиринг, төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагааг хангах тоног төхөөрөмжөөр хангах.										
4.1.1	Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих "Цагаан алт" хөдөлгөөний хэрэгжилтийн хүрээнд арилжаа, төлбөр тооцоог эрсдэлгүй гүйцэтгэх, өгөгдөл мэдээлэл солилцох, үүсмэл санхүүгийн хэрэгсэл арилжих нөхцөлийг бүрдүүлсэн Монгол Улсын онцлогт тохирох олон улсын таваарын биржийн системийг сонгох, нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээг авах, хэрэгжүүлэх;	тоо	Баримт бичиг	0	1					СУХ
4.1.2	Биржийн үйл ажиллагаанд ашиглагдах програм хангамж болон системийн сайжруулалт, сүлжээний найдвартай байдлыг хангах;	хувь	Хэрэгжилт	0%	100%					СУХ
4.1.3	"Арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн систем"-ийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах, шаардлагатай сайжруулалт, хөгжүүлэлтийг хийх;	хувь	Хэрэгжилт	0%	100%					СУХ
Дэд зорилт 4.2. Цахим шинэчлэлтийг хийх ажлын хүрээнд биржийн дэд бүтцийг хөгжүүлэх, дэд системүүдийг бий болгоход шаардлагатай тооцоо, судалгааг гаргах, боломжит системийг нэвтрүүлнэ.										
4.2.1	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн "Экспортын нэг цонхны систем"-ийн нэвтрүүлэлт, ашиглалт үйлчилгээ;	хувь	Хэрэгжилт	0%	100%					СУХ
4.2.3	"Багцын гэрээний НӨАТ систем"-ийн ашиглалт үйлчилгээ;	хувь	Хэрэгжилт	0%	100%					СУХ, YAX
Стратеги төлөвлөгөөний зорилго 5. Биржийн зах зээлд оролцогч руу чиглэсэн тэнцвэртэй бодлого хэрэгжүүлэх Дэд зорилт 5.1. Биржийн гишүүдийг чадавхжуулах, тэдгээрийг идэвхжүүлэх, нэмэгдүүлэх арга хэмжээг төсөв болон санхүүгийн төлөвлөгөөнд тулгуурлан авч хэрэгжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.										
5.1.1	Байнгын гишүүний гэрээ дүгнэж, сунгах, гишүүнчлэлийн гэрээ байгуулах, идэвхжүүлэх, тэдгээрт арга зүйн зөвлөгөө өгөх;	тоо	Тоо хэмжээ	4	5					YAX
5.1.2	Байнгын бус гишүүний гэрээ дүгнэж, сунгах, гишүүнчлэлийн гэрээ байгуулах, "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд үүсгэн байгуулагдсан хоршоодыг чадавхжуулах, идэвхжүүлэх, байнгын бус гишүүдэд цахим болон танхим хосолсон сургалт, арга зүйн зөвлөгөөг мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулах, гишүүдийн 10 хувийг хоршоо, үйлдвэр холбосон арилжаанд оролцуулах;	тоо	Тоо хэмжээ	30	50					YAX
5.1.3	Биржийн гишүүдийг чадавхжуулах, биржийн арилжаанд оролцогчийн эрх олгох, түүнийг сунгах зорилгоор мэргэжлийн оролцогч бэлтгэх сургалтыг Санхүүгийн зохицуулах хороо болон "МХААГБТЭБНМБНХолбоо" ТББ-тай хамтран зохион байгуулах;	тоо	Арга хэмжээ	0	1					YAX
5.1.4	Арилжааны зах зээлд оролцогчдод биржийн барааны код олгогчийн сургалтыг бараа, түүхий эдийн чанар, баталгаажуулалтын асуудал эрхэлсэн мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;	тоо	Арга хэмжээ	0	1					YAX
Дэд зорилт 5.2. Малчин, тариалан эрхлэгчдийн оролцоог идэвхжүүлж, арилжаанд оролцох боломжийг төсөв болон санхүүгийн төлөвлөгөөнд тулгуурлан бүрдүүлж, орлогыг нэмэгдүүлнэ.										

5.2.2	Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих "Цагаан алт" хөдөлгөөний хэрэгжилтийн хүрээнд малын гаралтай түүхий эдийг биржээр арилжаалах, түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалтыг бий болгож, нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх, оролцогчдыг биржийн үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээллээр тогтмол хангах, биржийн арилжаанд татан оролцуулах;	тоо	Арга хэмжээ	0	4					YAX
5.2.3	"Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ыг улс даяар өрнүүлж буйтай холбогдуулан газар тариалангийн бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэх, урьдчилсан захиалгат тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, цахим худалдааны маркетинг зохион байгуулах боломжийг бүрдүүлэх, оролцогчдыг биржийн үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээллээр тогтмол хангах, биржийн арилжаанд татан оролцуулах;	тоо	Арга хэмжээ	0	2					YAX
5.2.4	Хөдөө аж ахуйн салбарын үйлвэрлэл эрхлэгч малчин, тариаланч, хоршоо, үйлдвэрүүдийг биржийн үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээллээр тогтмол хангах, тэдгээрийг чадавхжуулах цахим болон танхим хосолсон сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах, тэдгээртэй хамтран ажиллах, биржийн арилжаанд татан оруулах;	тоо	Арга хэмжээ	0	4					YAX
Дэд зорилт 5.3. Гадаад болон дотоодын худалдан авагч, үйлдвэрүүдийг биржийн арилжаанд оролцох тэгш боломжоор хангах нөхцлийг төсөв болон санхүүгийн төлөвлөгөөнд тулгуурлан бүрдүүлнэ.										
5.3.1	Гадаад, дотоодын худалдан авагч, үйлдвэрүүдийг биржийн арилжаанд оролцох хялбар, таатай нөхцөлийг бүрдүүлэх, мэдээ мэдээллийг хүргэх, биржийн арилжаанд оролцох тэгш боломжоор хангах, хамтран ажиллах;	хувь	Хэрэгжилт	0%	100%					YAX
5.3.2	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах "Хүнсний хувьсгал" хөдөлгөөний хэрэгжилттэй уялдуулан боловсрол, сургалтын байгууллагад суралцагчийн хоол үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн арилжааг "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай" хуулиар хуульчилсаны дагуу биржээр дамжуулан зохион байгуулах, хангамжийн цахим тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга замыг тодорхойлох, хүнсний боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой явуулах, бүтээгдэхүүнийг экспортлох арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулах;	хувь	Хэрэгжилт	0%	100%					YAX
Стратеги төлөвлөгөөний зорилго 6. Биржийн дэд бүтцийг сайжруулах										
Дэд зорилт 6.1. Биржийн итгэмжлэгдсэн этгээдийн оролцоог нэмэгдүүлж, идэвхжүүлэн ложистикийн үйл ажиллагааг сайжруулна.										
6.1.1	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогын дагуу биржээр арилжих бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн оновчтой тогтолцоо, нийлүүлэлтийн сүлжээг бүсчлэлээр дамжуулан бүрдүүлэх арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран зохион байгуулах, бүсчлэлийн дагуу биржийн үйл ажиллагааг эрхлэх нөхцөл боломжийг тодорхойлж, танилцуулах;	хувь	Хэрэгжилт	0%	100%					YAX
6.1.2	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг хадгалах, анхан шатны тордолт хийх чиг үүрэг бүхий агуулахын суурь дэд бүтцийн судалгаа, эдийн засгийн тооцоолол, барилгын зураг төсөл, төсвийг тусгасан агуулахын загвар боловсруулах;	тоо	Баримт бичиг	0	1					YAX

6.1.3	Үйлдвэрийн дэргэдэх итгэмжлэгдсэн агуулахуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх, нэмэгдүүлэх;	тоо	Агуулахын тоо	20	25					YAX
6.1.4	Орон нутгийн итгэмжлэгдсэн агуулахуудын үйл ажиллагааг идэвхжүүлж, нэмэгдүүлэх;	тоо	Агуулахын тоо	4	20					YAX
Дэд зорилт 6.2. Ложиستيкийн төвийн үйл ажиллагааг төсөв болон санхүүгийн төлөвлөгөөнд тулгуурлан идэвхжүүлнэ. Малын гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэх, чанарыг тодорхойлох, хадгалах, боловсруулах, тээвэрлэх болон бараа, түүхий эдийн танхимын арилжаа, амьд малын спот арилжааг дуудлага худалдааны хэлбэрээр зохион байгуулах үйл ажиллагааг явуулна.										
6.2.1	Ложиستيкийн төвийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай тордолт, засвар үйлчилгээг цаг тухай бүр хийж гүйцэтгэх;	тоо	Хэрэгжилт	0	1					YAX, СУХ
6.2.2	Ложиستيкийн төвд амьд мал болон малын гаралтай бараа, түүхий эдийн арилжааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, арилжааг зохион байгуулах;	тоо	Арга хэмжээ	0	2					YAX

Гүйцэтгэх төлөвлөгөөт ажил - 60

Нийт гүйцэтгэсэн ажлын тоо

Гүйцэтгэлийн үнэлгээ